



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Ө.Бадрахын гудамж, Улаангом, Увс аймаг, 85165

Утас/факс: 7045-3317

Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2026.05.29 № 359
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БАТТУЯА ТАНАА**

Төрийн аудитын байгууллагын 2026 оны
гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу
Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн
нийцэлд хийсэн нийцлийн аудитын тайланг
хүргүүлж байна.

Хавсралт: ⁴⁸ хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.БАТСУУРЬ

8525070827



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖИЖ БАЙГАА Ч ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН ЗАРИМ ЗААЛТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖГҮЙ,
ДОТООД ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ
БАЙНА.

ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ

АУДИТЫН КОД: УВА-2026/14-19-ШТА-НА

Улаангом хот 2026 он

Дарга, тэргүүлэх аудитор **М.Батсуурь**

Утас: 70453317 Цахим хаяг: batsuurim@audit.gov.mn

Аудитын менежер **М.Бат-Амгалан**

Утас: 70453317 Цахим хаяг: batamgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор **Т.Намжил**

Утас: 70453317 Цахим хаяг: Namjilt@audit.gov.mn

Аудитор **Т.Амармэнд**

Утас: 70453317 Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Аудитор **Т.Батсүх**

Утас: 70453317 Цахим хаяг: Batsukht@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
Open.audit.mn хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/18

Улаангом

Аудитын тайлан баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэлд хийсэн нийцлийн аудитын тайланг (УВА-2026/14-19-ШТА-НА) хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Т.Намжил нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



АГУУЛГА	3-4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	4
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	5
ГРАФИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	5
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	6
Аудитын зорилт	6
Аудитын хамарсан хүрээ	6
Аудитын арга зүй	6
Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа	6
Аудитын дүн	7
Ерөнхий мэдээлэл	7-8
БҮЛЭГ 1 Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн байна	9
1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа ч Төрийн сангийн үйл ажиллагааны журмын зарим заалт хэрэгжих боломжгүй байна.	9
1.1.1. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд хоорондоо нийцэж байна уу? /АНТАГ-т хамаарахгүй/	9
1.1.2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байгаа ч Төрийн сангийн үйл ажиллагааны журам, салбарын сайдын тушаалын зарим заалт хэрэгжих боломжгүй байна.	9-11
1.2. Хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх Төрийн сангийн зохистой бүтэц бүрдсэн ч Улаангом сумын Төрийн сангийн 1 мэргэжилтнийг Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд шилжүүлэн ажиллуулж байна.	11
1.2.1. Төрийн сангийн үйл ажиллагааг явуулж буй бүтэц, зохион байгуулалт жишиг нормативд нийцэж байгаа ч Улаангом сумын Төрийн сангийн 1 мэргэжилтнийг Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд шилжүүлэн ажиллуулж байна.	11-14
1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй байгаа ч албан тушаалын тодорхойлолтод тухайн ажлын байранд хамааралгүй чиг үүрэг тусгасан болон Засгийн газрын тогтоолд нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.	14-18
1.2.3. Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа ч систем хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.	18-20
БҮЛЭГ 2 Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байна.	21
2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа ч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалтын эрхийг 2025 онд бүрэн олгоогүй байна.	21
2.1.1. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь, хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж байгаа ч санхүүжилтийг хугацаанд нь олгох боломжгүй байна.	21-23
2.1.2. Төсвийн зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, зориулалт, эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцэж байгаа ч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалтын эрхийг 2025 онд бүрэн олгоогүй байна.	24-27
2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажуулж, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байгаа ч зарим төрлийн зөрчлийг давтан гаргасаар байна.	27
2.2.1. Аймгийн Төрийн сангаар харилцдаг улсын төсвийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгааг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу тулган, хянаж баталгаажуулж байна.	27-28
2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллага бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээг хийхдээ зарим төрлийн зөрчлийг давтан гаргасаар байна.	28-31
2.2.3. Бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцаасан тохиолдол гараагүй байна.	31



2.2.4.	Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнаж байна.	31-34
2.3.	Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо дахь дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.	34
2.3.1.	Санхүү, Төрийн сангийн хэлтсээс 2023-2025 онд нийт 18 суманд төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 суманд буюу 33.3 хувьд нь дотоод хяналтыг, 3 сумын Төрийн санд төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хэрэгжүүлсэн ч зөрчил давтагдан гарсаар байна.	34-39
2.3.2.	Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлж, өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлсэн ч Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн дотоод хяналтын тайланд тусгаагүй байна.	39-40
2.3.3.	Төрийн сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.	40-41
	Дүгнэлт	42-43
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	44
	ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР	45
	ЗӨВЛӨМЖ	46
	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН НЭГТГЭЛ ТАЙЛАНД ТУСГУУЛАХААР УЛАМЖЛАХ САНАЛ	47-48

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон Улсын стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
СЯ	Сангийн яам
ШТА	Шууд тайлагнах аудит
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
АНТАГ	Аймаг, нийслэлийн төрийн аудитын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СХДАА	Санхүү хяналт, дотоод аудитын алба
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХЖТ	Хөгжимт жүжгийн театр
ХБИХХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн харилцаа
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
МЭҮ	Мал эмнэлэгийн үйлчилгээ
БОХНСАХ	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНТ	Орон нутгийн төсөв
УТБ	Улсын төсвийн байгууллага
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем

**ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгтын дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбарын тодорхойлолт	11
2	Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй нэгж, албан хаагчдын судалгаа	12
3	Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй нэгж, албан хаагчдын судалгаа	13
4	Аймгийн санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл	15
5	Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт	15
6	Сумдын Төрийн сангийн албан хаагчдын ажлын байрны	16-17
7	Аймаг, сумдын Төрийн сангийн 2024, 2025 оны гүйлгээний тоо мэдээ Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгааны дүн	17-18
8	Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгааны дүн	18-19
9	Төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдийн судалгааны дүн	19
10	2023-2025 оны батлагдсан төсөв, санхүүжилтийн эрх	21-23
11	Төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгаа	27-28
12	Тогтмол зардлын гүйлгээнд хийсэн түүврээр илэрсэн зөрчил	29-30
13	Тогтмол зардлын түүврээр тухайн үед залруулсан гүйлгээ	30
14	Төрийн сангийн 2023-2025 оны өдөр тутмын дотоод хяналтаар буцаасан гүйлгээ	40
15	Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2023-2025 оны Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнгээс	41

ГРАФИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Графикын дугаар	Нэр	Хуудасны дугаар
1	Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдаас авсан судалгааны дүн	19
2	Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгааны дүн	20
3	Төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдийн судалгааны дүн	20
4	Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн нэгтгэл	26
5	Төсөвт байгууллагуудын зардлын зохицуулалт	27
6	Улсын төсөв хоорондын тооцоо 2023-2025 оны харьцуулалт	34

**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”, “Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар Монгол Улсад Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, Төсвийн төвлөрүүлэн захирагчид, Санхүү, Төрийн сангийн хэлтэс болон сумдын Төрийн сангуудын 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэхэд болон хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийсэн.

Аудитын хүрээнд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс болон 19 сумдын төрийн санд албан бичиг хүргүүлэн холбогдох мэдээлэл, судалгааг авч нэгтгэсэн бөгөөд 6 суманд очиж ажилласан.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласан.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа

Нийцлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан арга зүйгээр ханган, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Намжил, аудитор Т.Амармэнд, Т.Батсүх нар 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 5 дугаар сарын 29-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэлд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгч, Үндэсний аудитын газарт 5 санал хүргүүлсэн болно.

Аудитын тайланд өмнөх онуудад Увс аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн Санхүүгийн тайлангийн аудитаар болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн гүйцэтгэсэн дотоод хяналтаар илрүүлсэн төрийн сангийн хэрэгжилттэй холбоотой зөрчлүүдийг давхардуулан тусгаагүй болно.

Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “Төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг” гэж тодорхойлж, мөн хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Монгол Улсын хэмжээнд Төв Төрийн сан, 16 Төрийн захиргааны төв байгууллагын Санхүү, хөрөнгө оруулалтын газар, хэлтэс, 21 аймаг, 9 дүүрэгт Санхүү, Төрийн сангийн хэлтэс, 330 сум, 9 тосгонд Санхүүгийн алба, нийт 390 Төрийн санд 993 албан хаагч үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 2002 онд Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнээс системийн сайжруулалтыг хийж ирсэн бөгөөд 2023-2025 онд 6,021.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сангийн яамны төлбөр тооцооны системүүд



Мөн банк хоорондын системийн шинэчлэлтэд Төрийн үйлчилгээний төлбөрийг олон хувилбараар төлөх нөхцөлийг бүрдүүлжээ.

Банк хоорондын системийн шинэчлэлт



*RTGS-Монгол банк дахь их дүнтэй гүйлгээний систем /5,000,001 төгрөгөөс дээш үнийн гүйлгээ/

*RTP- Монгол банк дахь бага дүнтэй гүйлгээний систем /5,000,000 төгрөгөөс доош үнийн гүйлгээ/



**АСН-Зөвшөөрөгдсөн гүйлгээ /Хүүхдийн мөнгө, НӨАТ-ын буцаалт, Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, ТАХ-ийн цалин/*

Системийн хэрэглэгчээр нь авч үзвэл эрхийн бүртгэлийн болон Төрийн сангийн удирдлагын цахим системийн хувьд 6,582 төсвийн байгууллага, 25,543 данс, 14,726 системийн хэрэглэгч, Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн хувьд 4,410 төсвийн байгууллага, 9,170 гаруй системийн хэрэглэгчтэй байна.

Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн нэгдсэн төсвийн 2025 оны урьдчилсан гүйцэтгэлийн мэдээгээр 2025 оны нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл 32,646.0 тэрбум, зарлагын гүйцэтгэл 31,289.2 тэрбум, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл (1,231.5) тэрбум төгрөг байна.

Увс аймгийн хувьд Санхүү, төрийн сангийн хэлтэс, 19 сумын Санхүүгийн алба, нийт 20 төрийн сан, 47 ажилтан үйл ажиллагаа явуулж байна.

**БҮЛЭГ 1****Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн байна.**

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа ч Төрийн сангийн үйл ажиллагааны журмын зарим заалт хэрэгжих боломжгүй байна.

1.1.1. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд хоорондоо нийцэж байна уу? /АНТАГ-т хамаарахгүй/

1.1.2. Холбогдох эрх бүхий албан тушаалтнуудын Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрүүд хууль тогтоомжтой нийцэж байгаа ч Төрийн сангийн үйл ажиллагааны журам, салбарын сайдын тушаалын зарим заалт хэрэгжих боломжгүй байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.1-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага Монгол банкттай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно", 3.6.2-т "Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн Төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна", Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-ын 2.1-д "Энэ журмын үйлчлэх хүрээнд Засгийн газрын болон төсвийн байгууллагын банк дахь дараах данс хамаарна", 2.1.9-д "Бэлэн мөнгөний зарцуулалт гаргах зориулалттай картын данс" гэж тус тус заасны дагуу 2025 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 12.9 сая, аймгийн Засаг даргын тамгын газар 530.8 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг арилжааны банканд байрших кассын дансаар дамжуулан хийсэн байна.

Харин Монгол улсын Сангийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 103 дугаар "Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Төв Төрийн сангаас Увс аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийхдээ аймгийн хэмжээнд 26 төсөвт байгууллагын бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэх 27 данс ашиглаж байснаас, 3 дансыг дотоод хяналтын мэргэжилтэн тухайн байгууллагад нь чиглэл өгч хаалгасан, мөн Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/9469 дүгээр албан бичгээр Төсвийн ерөнхийлөн захирагч нарт ирүүлсэн "Хамтран ажиллах тухай чиглэл"-ийн 3-д "Төсвийн байгууллагын төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэж байгаа тул байгууллагын цалин, жижиг мөнгөн сангийн данснуудыг хааж, хаасан тухай мэдээлэл ирүүлэх", 4-д "Арилжааны банкин дахь зөвшөөрөлгүй данснуудыг хааж, хаасан тухай мэдээллийг ирүүлэх" гэж заасны дагуу бусад төсвийн байгууллагуудын арилжааны банкин дахь дансыг хаалгасан байна.

Үүнээс шалтгаалан Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсвийн байгууллагууд нярвын дансаар дамжуулан бэлэн мөнгө гаргаж зарцуулсан зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн. Үүнд:



- Завхан сумын Засаг даргын тамгын газар 35.9 сая,
- Баруунтуруун сумын Засаг даргын тамгын газар 23.8 сая,
- Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар 8.3 сая,
- Сагил сумын Засаг даргын тамгын газар 8.8 сая,
- Малчин сумын Засаг даргын тамгын газар 4.0 сая төгрөгийг тус тус нярвын дансаар дамжуулан зарцуулсан.

Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/9469 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэл нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" болон Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам"-тай нийцэхгүй байгаа тул дээрх асуудлыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулах санал хүргүүлээ.

Аймгийн Засаг дарга сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг хууль, тогтоомжийн хүрээнд жил бүр баталж байна. Түүнчлэн орон нутгийн эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс 2023-2025 онд бүтэц, орон тоо, цалин тогтоолтоос өөрөөр Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэг тушаал, шийдвэрүүд гаргаагүй байна.

Бүтэц орон тоо, цалин тогтоолттой холбоотой гаргасан тушаал, шийдвэрүүд нь хууль тогтоомжтой нийцэж байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.6-д "Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох журам"-ын:

- 2.6.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно;
- 2.6.2.Аймаг, нийслэлийн Төрийн сан нь энэ журмын 2.4.9, 2.4.13-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг ажлын 2 өдөрт багтаан мөн журмын 24 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан сум, дүүргийн зохих дансанд хуваарилна гэж заажээ.

Гэтэл улсын төсвөөс татаас авдаг аймгийн хувьд улсын төсвийн татаас санхүүжилт сар бүрийн 8-ны өдрөөс хойш санхүүжигддэг болон орон нутгийн орлого төвлөрүүлэлтээс хамаарч дээрх журмын цаглаварт хугацааг баримтлах боломжгүй байдал үүсдэг байна.

Мөн журмын 2.6.3-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төрийн сан нь энэ журмын 2.6.10-2.6.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг мөн журмын 2.5.6-д заасантай адилаар санхүүжүүлнэ" гэж заасан ч орон нутгийн хувьд журмын 2.6.10-2.6.14-т заасан зориулалт бүхий зардлын хувьд санхүүжилтийн эрх олголтыг үндэслэн санхүүжүүлж байх бөгөөд журмын 2.6.3 дахь заалт орон нутгийн түвшинд хэрэгжих боломжгүй байна.

Дээрх журмын орон нутагт мөрдөгдөхгүй байгаа 3 заалтын хүрээнд журамд нь өөрчлөлт оруулах асуудлыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлээ.

Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-т дараах 2 зардлын ангиллын тодорхойлолт хоорондоо нийцэхгүй байна. Үүнд:

**Хүснэгт-1 /Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбарын тодорхойлолт**

Д/д	Код	Зардлын эдийн засгийн зүйлс	Тодорхойлолт
1	210502	Хоол, хүнс	Хамаарахгүй зүйлс: Хурал зөвлөгөөн сургалт, семинарын хоолны зардал. Энэ нь Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ ангилалд бүртгэнэ..... гэж заасан байхад
2	210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	Хамаарахгүй зүйлс: Сургалтад оролцох томилолт, унаа, хоолны зардал . Эдгээр нь Дотоод албан томилолт /210701/, Гадаад албан томилолт /210702/ ангилалд бүртгэгдэнэ гэж тусгасан байна

/Эх сурвалж: Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт /

Дээрх тушаалын зохицуулалтаас харахад хурал зөвлөгөөн, сургалт, семинарын хоолны зардлыг эдийн засгийн аль ангиллаас гаргах нь тодорхойгүй байх тул тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах асуудлыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлээ.

1.2. Хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх Төрийн сангийн зохистой бүтэц бүрдсэн ч Улаангом сумын Төрийн сангийн 1 мэргэжилтнийг Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд шилжүүлэн ажиллуулж байна.

1.2.1. Төрийн сангийн үйл ажиллагааг явуулж буй бүтэц, зохион байгуулалт жишиг нормативд нийцэж байгаач Улаангом сумын Төрийн сангийн 1 мэргэжилтнийг Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд шилжүүлэн ажиллуулж байна.

Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолоор санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг баталсан байна. Энэ тогтоолын 1.1-т “Албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч” гэж заажээ. Үүнд:

- 1.1.1. Сумын санхүү, эдийн засаг, төсвийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулж, түүнд хяналт тавих
- 1.1.2. Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн боловсруулах
- 1.1.3. Орон нутгийн хөгжлийн сан, тусгай зориулалтын шилжүүлэг, сумын нэгдсэн төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хийж орон нутгийн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын нягтлан бодогч болон Төрийн сангийн мэргэжилтнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- 1.1.4. Төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох;
- 1.1.5. Төрийн сангийн гүйлгээг хянан баталгаажуулах
- 1.1.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг холбогдох журмын дагуу санхүүжүүлэх
- 1.1.7. Орон нутгийн өмчийн хяналт, бүртгэлийг хэрэгжүүлэх
- 1.1.8. Зээл, тусламжийн хэрэгжилтийг зохион байгуулж, түүнд хяналт тавих
- 1.1.9. Сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор сумын татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангаж ажиллах
- 1.1.10. Харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хүлээн авч шалгах, залруулга хийх, нэгтгэх, дүн шинжилгээ хийх

Мөн журмын 1.2-т “Төсөв, Төрийн сангийн мэргэжилтэн” гэж заажээ. Үүнд:

- 1.2.1. Төрийн сангийн үйлчилгээ үзүүлэх
- 1.2.2. Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн нэгтгэл, хяналт



- 1.2.4. Статистик мэдээллийг гаргах
- 1.2.5. Аж ахуйн нэгж, байгууллагын улирал, жилийн эцсийн санхүүгийн тайланг хянаж, хүлээн авах

Увс аймгийн хэмжээнд Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын бүтэц, чиг үүргийн судалгаа авч нэгтгэл хийхэд аймгийн хэмжээнд Төрийн сангийн чиг үүрэгт харьяалагдаж байгаа нэгжийн батлагдсан орон тоо 47 албан хаагч, гүйцэтгэлээр 47 албан хаагч ажиллаж байна.

Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдаас аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст 8 албан хаагч, Улаангом сумын Төрийн санд 3 албан хаагч, бусад сумдад тус бүр 2 албан хаагч ажиллаж байна. Үүнд:

Увс аймгийн хэмжээнд Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй нэгж, албан хаагчдыг дараах хүснэгтэд харууллаа. Үүнд:

Хүснэгт-2 /Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй нэгж, албан хаагчдын судалгаа/

№	Төрийн сангийн чиг үүрэг харьяалагдаж байгаа нэгжийн нэр	Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэх албан тушаалын нэр	Орон тоо
1	Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс	Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч Орон нутгийн төсвийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Нягтлан бодох бүртгэлийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /Улсын байцаагч/ Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн /2 орон тоотой/ Татвар, орон нутгийн төсвийн орлогын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	8
2	Баруунтуруун сумын Төрийн сан	1. Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч 2. Төсөв Төрийн сангийн мэргэжилтэн	2
3	Бөхмөрөн сумын Төрийн сан		2
4	Давст сумын Төрийн сан		2
5	Завхан сумын Төрийн сан		2
6	Зүүнговь сумын Төрийн сан		2
7	Зүүнхангай сумын Төрийн сан		2
8	Малчин сумын Төрийн сан		2
9	Наранбулаг сумын Төрийн сан		2
10	Өлгий сумын Төрийн сан		2
11	Өмнөговь сумын Төрийн сан		2
12	Өндөрхангай сумын Төрийн сан		2
13	Сагил сумын Төрийн сан		2
14	Тариалан сумын Төрийн сан		2
15	Түргэн сумын Төрийн сан		2
16	Тэс сумын Төрийн сан		2
17	Ховд сумын Төрийн сан		2
18	Хяргас сумын Төрийн сан		2
19	Цагаанхайрхан сумын Төрийн сан		2
20	Улаангом сумын Төрийн сан	Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч Төсөв Төрийн сангийн мэргэжилтэн ОНХСан, орлого хариуцсан мэргэжилтэн	3
Нийт			47

/Эх сурвалж: Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаа/

Төрийн сангийн чиг үүргийн 47 ажлын байрнаас 4 ажлын байранд албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ажиллаж байна. Үүнд:



Хүснэгт-3 /Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэж буй нэгж, албан хаагчдын судалгаа/

Түр орлон гүйцэтгэгч/үндсэн орон тоонд ажиллаж байгаа эсэх	
Үндсэн орон тоо	Түр орлон гүйцэтгэгч
43	4

/Эх сурвалж: Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаа/

Дээрх хүснэгтээс харахад Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдаас Давст, Наранбулаг сумдын Санхүү албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийн, Бөхмөрөн, Давст сумдын төсөв Төрийн сангийн мэргэжилтний орон тоонд 4 албан хаагч албан үүргийг түр орлон гүйцэтгэж байна. Энэ нь тухайн ажлын байранд ажиллаж байгаа албан хаагчид ажлаас чөлөөлөгдсөн, жирэмсний болон амаржсаны амралттай, өөр ажилд шилжин ажиллаж байгаагаас шалтгаалсан байна. Тухайн сул орон тоонд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу хүргүүлж сонгон шалгаруулалт зарласан байна.

Увс аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/10 дугаар захирамжаар Санхүү, төрийн сангийн хэлтсийн орон тоог “Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан ажилтан” гэсэн 1 орон тоогоор нэмэгдүүлж 9 орон тоотой байхаар баталж, 2025 оны 08 дугаар сарын 21-ний А/459 дүгээр захирамжаар тухайн нэмэгдүүлсэн орон тоог чиг үүргийн дагуу Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст шилжүүлж 8 орон тоотой ажиллаж байна.

Харин Улаангом сумын ЗДТГ-ын бүтэц орон тоонд төсөв, төрийн сангийн 2 мэргэжилтний орон тоо байгаа боловч 2025 онд санхүү албаны дарга тэтгэвэрт гарч төсөв төрийн сангийн 1 мэргэжилтэн нь түр орлон гүйцэтгэсэн, Улаангом сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай аймгийн Засаг даргын орлогчийн 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/36 дугаар захирамжаар төсөв төрийн сангийн мэргэжилтний нэг орон тоог бууруулан, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн татвар, орон нутгийн төсвийн орлогын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын гүйцэтгэх чиг үүрэгтэй адил чиг үүрэг бүхий татвар, төсвийн орлогын бодлого зохицуулалт хариуцсан ажилтны нэг орон тоог нэмж баталсан байна.

Улаангом сумын Засаг даргын тамгын газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн Б/09 дүгээр тушаалаар дээрх шинээр батлагдсан ажлын байранд ТҮ-6 ангилал, зэрэглэлээр төрийн үйлчилгээний албан хаагч томилж, Улаангом сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/09 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан байна.

Ингэхдээ Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ын ТҮ-6 ангилал зэрэглэлийг баримталсан нь тухайн албан тушаалд хамааралгүй байна.

Төрийн захиргааны ажлын байрны ажлын чиг үүрэгт зохицуулалт хийх нэрийдлээр Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд шилжүүлэн ажиллуулж байгаа дээрх асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх зөвлөмжийг холбогдох эрх бүхий албан тушаалтанд өглөө.



1.2.2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй байгаа ч албан тушаалын тодорхойлолтод тухайн ажлын байранд хамааралгүй чиг үүрэг тусгасан болон Засгийн газрын тогтоолд нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заажээ. Үүнд:

- 37.1.1.Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих
- 37.1.2.Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх
- 37.1.3.Төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх
- 37.1.4.Төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;
- 37.1.5.Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих
- 37.1.6.Төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;
- 37.1.7.Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах;
- 37.1.8.Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

Увс аймгийн хэмжээнд Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй нийт 47 албан хаагч байгаагаас Санхүү, төрийн сангийн хэлтэст 8 албан хаагч, Улаангом сумын төрийн санд 3 албан хаагч, бусад сумдад тус бүр 2 албан хаагч ажиллаж байна. Тухайн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүргийн хувьд давхардал байхгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмыг Төрийн албаны төв байгууллага батална”, 23.6 дахь хэсэг “Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, Төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална” гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 356 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/53 дугаар тушаалаар шинэчлэн баталжээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолоор Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр баталсны дагуу аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 215 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын дагуу, сумдын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 208 дугаар тогтоолын дагуу шинэчлэн баталсан байна.

Харин аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн зарим албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт дахь ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулаагүй хэвээр байна. Үүнд:



Хүснэгт-4 /Аймгийн санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл/

№	Аймгийн засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/53 дугаар тушаалаар шинэчлэн баталсан албан тушаалын тодорхойлолт	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол	
	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал зэрэглэл	Албан тушаалын ангилал зэрэглэл
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /Улсын байцаагч/	ТЗ-6	ТЗ-7
2	Орон нутгийн төсвийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-6	ТЗ-7
3	Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	ТЗ-7
4	Татвар, орон нутгийн төсвийн орлогын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	ТЗ-8
5	Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	ТЗ-8

/Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын 2022 оны А/53 дугаар тушаал, ЗГ-ын 2022 оны 487 дугаар тогтоол/

Иймд аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгасан ангилал, зэрэглэлийг Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолд нийцүүлэн өөрчлөлт оруулах зөвлөмжийг эрх бүхий албан тушаалтанд өглөө.

Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй 47 албан хаагчаас авсан судалгаанд ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг эсэх, Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг эсэх гэсэн асуултад албан хаагчид дараах байдлаар хариулжээ. Үүнд:

Хүснэгт-5 /Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт/

Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг Төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг үү?	
Нийцдэг	Нийцдэггүй
43	4
Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг үү?	
Тийм	Үгүй
0	47

/Эх сурвалж: Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, бүтэц, чиг үүргийн судалгаа/

- ❖ Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй 47 албан хаагчаас 43 албан хаагч нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг Төрийн сангийн сангийн нийтлэг үүрэгтэй нийцдэг, 4 албан хаагч нийцдэггүй гэж санал ирүүлсэн байна. Нийцдэггүй гэж ирүүлсэн 4 албан хаагч Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг нь Төрийн сангийн чиг үүрэгт байдаггүй, мөн орон нутгийн төсвийн байгууллагуудын урамшууллыг тооцож, холбогдох журмын дагуу бодож олгохгүй байгаа нь төсөв, санхүүжилт байдаггүйтэй холбоотой гэсэн тайлбар ирүүлжээ.
- ❖ Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй 47 албан хаагчид 100 хувийн саналаар ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэггүй гэж санал ирүүлсэн байна.



Харин Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ”, 37.1.13 дахь заалтад “Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах” гэж заасан байхад Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 208 дугаар тогтоолын 2, 3 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч, Төсөв, Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаалд хамааралгүй дараах чиг үүргийг тусгасан байна. Үүнд:

Хүснэгт-6 /Сумдын Төрийн сангийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан зарим чиг үүрэг/

Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч	
Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг	Тайлбар
Төсвийн тухай хуулийн дагуу нэмэлт төсвийн эрхийг төсвийн байгууллагад хянан олгох	Төсвийн тухай хуулийн дагуу нэмэлт төсвийн эрхийг олгох эрх нь системээр аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэст байна.
Орон нутгийн төсвийн байгууллагын урамшууллын тооцоог холбогдох журмын дагуу хийх, хуваарилах, санхүүжилт олгох	Үр дүнд суурилсан санхүүжилтийн үед мөрдөгдөж байсан бөгөөд хөтөлбөрт суурилсан санхүүжилтэд шилжсэн тул мөрдөгдөхөөргүй байна.
Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж тайлан баланс гаргах	“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.6-д “..... сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч” тус тус зурахаар заасан байна.
Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг болон холбогдох үйл ажиллагааны тайлан, мэдээг боловсруулах, нэгтгэн тайлагнах, холбогдох байгууллагад дурдсан хугацаанд хүргүүлэх	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19.1.8 дахь заалтаар аймаг, сумдын Засаг дарга нар хэрэгжүүлэхээр байна.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох, дүрэм, журам, заавар, стандартуудыг мөрдөж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 ¹ .1 дэх хэсэгт зааснаар аймаг, сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны чиг үүрэгт хамаарахаар байна.
Төсөв, Төрийн сангийн мэргэжилтэн	
Ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан чиг үүрэг	Тайлбар
Монгол Улсын Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн орон нутагт хамааралтай зорилтуудыг хяналтад авч, хэрэгжилтийг хангах	Тухайн ажлын байрны чиг үүрэгт хамаарахгүй
Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд цахимаар илгээж байгаа эсэхэд хяналт тавих, тайланг нэгтгэх	Тухайн чиг үүрэг нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /Улсын байцаагч/-ийн чиг үүрэгт хамааралтай байна.



Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах, удирдлагаар батлуулж ажиллах Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох, дүрэм, журам, заавар, стандартуудыг мөрдөж ажиллах. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн сургалт, зөвлөгөөнд идэвхтэй оролцох, осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах	Шилэн дансны тухай хуулийн хүрээнд тухайн ажлын байрны чиг үүрэгт хамаарахгүй байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 ^{1.1} дэх хэсэгт зааснаар аймаг, сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны чиг үүрэгт хамаарахаар байна.
Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах	Тухайн албан тушаалд хамааралгүй байна. Учир нь Төрийн сангийн ахлахаас дээш албан тушаал бүхий ажилтнуудад хамаарахаар байна.

/Эх сурвалж: Албан тушаалын тодорхойлолт/

Түүнчлэн Төрийн сангийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж буй хянах, батлах үүрэгтэй албан хаагчдын хариуцаж буй байгууллагын тоо, санхүүжилтийн хэмжээнээс шалтгаалан ажлын ачаалал харилцан адилгүй байна. Үүнд:

Хүснэгт-7 /Аймаг, сумдын Төрийн сангийн 2024, 2025 оны гүйлгээний тоо мэдээ/

№	Сумын нэр	2025 он			2024 он		
		Гүйлгээний тоо	Хянаж буцаасан гүйлгээний тоо	1 өдөрт хийх гүйлгээний дундаж	Гүйлгээний тоо	Хянаж буцаасан гүйлгээний тоо	1 өдөрт хийх гүйлгээний дундаж
1	Баруунтуруун	1,849	70	7	2,098	37	8
2	Бөхмөрөн	1,929	143	8	1,936	172	8
3	Давст	1,583	125	6	1,939	78	8
4	Завхан	1,357	53	5	1,673	78	7
5	Зүүнговь	1,611	172	6	1,827	154	7
6	Зүүнхангай	1,511	26	6	1,795	40	7
7	Малчин	1,555	44	6	1,863	138	7
8	Наранбулаг	1,919	44	8	2,186	75	9
9	Өлгий	1,444	46	6	1,715	90	7
10	Өмнөговь	1,457	65	6	1,897	85	7
11	Өндөрхангай	1,907	229	8	2,279	233	9
12	Сагил	1,515	91	6	1,634	105	6
13	Тариалан	1,711	64	7	2,227	129	9
14	Түргэн	1,766	62	7	1,892	49	7
15	Тэс	1,890	70	8	2,266	92	9
16	Ховд	1,048	71	4	1,262	81	5
17	Хяргас	1,547	46	6	1,806	116	7
18	Цагаанхайрхан	1,498	34	6	1,740	27	7
19	Улаангом	10,612	677	42	11,933	692	47



20	Аймгийн Төрийн сан	22,856	1,832	91	28,082	1,603	111
Нийт дүн		62,565	3,964		74,050	4,074	

/Эх сурвалж: Төрийн сангийн удирдлага мэдээллийн цахим систем/

Аймаг, сумдын Төрийн сангаар 2024 онд 74,050 гүйлгээ, 2025 онд 62,565 гүйлгээ, нийт 136,615 гүйлгээг хянасан нь аймаг сумдын төсөв, Төрийн сангийн нийт 21 мэргэжилтэнд нэг өдөрт дунджаар 13 гүйлгээ ногдож байна. Судалгааны дүнгээс харахад 18 сумдын төсөв, Төрийн сангийн мэргэжилтэн өдөрт дунджаар 7 гүйлгээг хянан баталгаажуулж байхад Улаангом сумын төсөв, Төрийн сангийн мэргэжилтэн өдөрт дунджаар 44 гүйлгээг, аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн төлбөр тооцоо хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн өдөрт дунджаар 50 гүйлгээг хянаж баталгаажуулжээ.

Энэ нь аймаг, сумдын Төрийн сангийн мэргэжилтнүүдийн үндсэн чиг үүргийн ажлын ачаалал харилцан адилгүй байгааг харуулж байна. Харин аудитын хүрээнд зарим сумдад очиж ажиллахад болон аудитын хүрээнд авсан судалгааны дүнгээс харахад сумдын Төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан үндсэн чиг үүрэгт хамааралгүй зарим ажил нь ажлын ачаалал нэмэгдэхэд нөлөөлж байна. Тухайлбал: сумдын төсөв, Төрийн сангийн мэргэжилтнүүдийн хувьд статистик мэдээг хариуцдаг бөгөөд энэ хүрээнд хүн амын тооллого, малын тооллого, орон сууцны тооллого болон сар бүрийн статистикийн мэдээ тайланг нэгтгэн аймгийн статистикийн хэлтэст хүргүүлдэг байна.

Сумдын Төрийн сангийн мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтод тухайн ажлын байранд хамааралгүй чиг үүрэг тусгасан болон аймаг, сумдын Төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын ачаалал харилцан адилгүй байгаа дээрх асуудлыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлээ.

1.2.3. Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа ч систем хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ”, 20.2 дахь хэсэгт “Санхүүгийн мэдээллийн нэгдсэн тогтолцоо дахь мэдээлэл нь холбогдох шийдвэр, эрх зүйн акт, нягтлан бодох бүртгэлийн баримтаар баталгаажсан байна”, 20.3 дахь хэсэгт “Холбогдох байгууллага, албан тушаалтан төсвийн мэдээллийн тогтолцоонд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь оруулах, мэдээллийн үндсэн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах үүрэгтэй”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.5 дахь заалтад “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих” гэж тус тус заажээ.

Төрийн сангийн удирдлагын цахим систем хэрэгжиж эхэлснээр орон зай, байршлаас үл хамааран гүйлгээ илгээх, гүйлгээг хүлээн авч хянаж, баталгаажуулах зэргээр хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

Цахим системийн ашиглалтын талаарх төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй хянах, батлах чиг үүрэгтэй 41 албан хаагчаас судалгаа авахад дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-8 /Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгааны дүн/

№	Үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем ажлын хэрэгцээг хангаж байгаа эсэх	41	0



2	Төрийн сангийн ажлыг гүйцэтгэхэд цахим системээс гадна цаасан суурьтай баримт үйлддэг эсэх	34	7
3	Цахим систем ашиглахад тулгарч буй хүндрэл бэрхшээл	31	10
4	Төрийн сангийн үйл ажиллагааг цахим систем ашиглан орон зай үл хамааран гүйцэтгэх боломжтой эсэх	41	0
5	Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан эсэх	33	8

/Эх сурвалж: Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгаа/

Цахим системийг ашиглахад интернэтийн саатал, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, сургалт хангалтгүй зэрэг хүндрэл бэрхшээлтэй асуудал байгааг судалгаанд хамрагдсан албан хаагчдын дийлэнх нь онцолсон байна. Үүнд:

График-1 /Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдаас авсан судалгааны дүн/



/Эх сурвалж: Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгаа/

Увс аймгийн төсвийн байгууллагуудын Төрийн сангийн цахим системийн 112 хэрэглэгчдийг хамруулан хийсэн судалгаагаар системийг ашиглахад ойлгомжтой, хялбар, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа ч систем хоорондын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

Хүснэгт-9 /Төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдийн судалгааны дүн/

№	Үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем ажлын хэрэгцээг хангаж байгаа эсэх	112	0
2	Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар эсэх	109	3
3	Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чаддаг эсэх	94	18

/Эх сурвалж: Төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдийн судалгаа/

Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 16 хувь нь Төрийн байгууллагуудын системүүд хоорондоо мэдээлэл солилцдоггүй, давхар шивэлт их шаарддаг нэг мэдээллийг олон системд давтан оруулдаг талаар онцолсон байна. Тухайлбал:

- Боловсролын байгууллагын ашигладаг esis программ
- Шилэн дансны цахим хуудас, шил ажиллагааны цахим систем
- Худалдан авах ажиллагааны цахим систем Tender.gov.mn
- Цалингийн нэгдсэн систем

Мөн Төрийн сангийн цахим системийн талаар хэрэглэгчид дараах хүндрэл бэрхшээлийг арилгах шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- Сарын болон жилийн эцсээр систем удаашрах, гацах
- Төрийн сангийн гүйлгээг боловсруулж хадгалаад эргээд илгээхэд хяналтын хуудас дээрх баримтын он, сар, өдөр нь өөрчлөгддөг
- Буцаасан гүйлгээний хяналтын хуудасыг дахин шинээр бичих зөвхөн тухайн хэсгийг засварлаж болдоггүй
- Анхан шатны баримтыг системд оруулах үед тамга тэмдэг нь бүдэгрэх, тендерийн баримт бичгийг бүхэлд оруулах шаардлагатай болдог
- Төрийн санд сарын мэдээг цаасаар өгч байгааг цахим болгох

- Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс тухай бүр шуурхай шийдвэрлэх

Төрийн сангийн цахим системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь Монгол Улсын Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуульд үндэслэн хэрэгжиж байгаа эсэхэд Үндэсний аудитын газраас шинжээч томилон ажиллаж байна. Орон нутгийн Төрийн сангийн чиг үүрэг хэрэгжүүлэгч хянах албан тушаалтан төсвийн байгууллагын 1, 2 дугаар гарын үсэг зурах эрх бүхий албан хаагчдын холбогдох мэдээллийг эрхийн бүртгэлийн цахим системд бүртгэн эрх олгож байгаа бөгөөд аудитын явцад эрхийн бүртгэлийн цахим системд хандах эрхийг өгөөгүй тул цаасан суурьт баримтанд хяналтыг хэрэгжүүлсэн болно.

График-2 /Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгааны дүн/



Судалгаанд хамрагдсан төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй хянах, батлах эрхтэй 41 албан хаагчдаас аюулгүй байдал хангагдсан эсэх талаар авсан асуумжид 33 албан хаагч буюу 80 хувь нь системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзсэн бол 2 албан хаагч буюу 5 хувь нь хангагдаагүй, харин 6 албан хаагч буюу 15 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

/Эх сурвалж: Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын судалгаа/

График-3 /Төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдийн судалгааны дүн/



Судалгаанд хамрагдсан Төрийн сангийн цахим системийн хэрэглэгч буюу төсвийн байгууллагын 112 албан хаагчдаас аюулгүй байдал хангагдсан эсэх талаар авсан асуумжид 64 хэрэглэгч буюу 57 хувь нь системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзсэн бол 5 хэрэглэгч буюу 5 хувь нь хангагдаагүй, 43 хэрэглэгч буюу 38 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

/Эх сурвалж: Төрийн сангийн цахим системийн хэрэглэгчдийн судалгаа/

Төрийн сангийн удирдлагын цахим системийг нэвтрүүлснээр Төрийн сангийн төлбөр тооцооны үйл ажиллагаа цахимжиж, төсвийн байгууллагын санхүүгийн гүйлгээ, мэдээллийн нэгдмэл байдал, хяналтын тогтолцоо, мөн цаасан суурьт ажиллагаа, гараар мэдээлэл боловсруулах үйл явц буурснаар цаг хугацаа, зардал хэмнэж, Төрийн үйлчилгээг иргэн, байгууллагад илүү шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдсэн хэдий ч тоног төхөөрөмжийн хүртээмж, интернэтийн хурд болон мэдээллийн аюулгүй байдал, хэрэглэгчдийн мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалт, гарын авлагаар хангах, систем хоорондын уялдаа, мэдээллийн солилцоог сайжруулах шаардлагатай байна.

**БҮЛЭГ 2**

Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж байна.

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа ч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалтын эрхийг 2025 онд бүрэн олгоогүй байна.

2.1.1. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь батлагдсан төсвийн хуваарь, хууль тогтоомж, холбогдох баримт бичгийн шаардлагад нийцэж байгаа ч санхүүжилтийг хугацаанд нь олгох боломжгүй байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.8 дахь заалтад “Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.1-д “Төрийн сан төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг Төсвийн тухай хуулийн 37.1.8-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн олгоно”, Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 3.1-д “Төсвийн санхүүжилт болон зарцуулалтын эрх нь тухайн байгууллагын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт нийцсэн байна” гэж заасны дагуу аймаг, сумдын төсвийн санхүүжилтийн эрхийг олгосон байна.

Аймгийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг 2023-2025 онд дараах байдлаар баталжээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/18 дугаар захирамжаар анх баталж, 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/407 дугаар захирамжаар өөрчлөн хуваарийн дагуу нийт 27,574.4 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг баталсан байна.
- Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/11 дүгээр захирамжаар анх баталж, 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/709 дүгээр захирамжаар өөрчлөн хуваарийн дагуу нийт 43,297.6 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг баталсан байна.
- Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/14 дүгээр захирамжаар анх баталж, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/529 дүгээр захирамжаар өөрчлөн хуваарийн дагуу нийт 45,314.3 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг баталсан байна.

Аймгийн 2023-2025 оны жилийн төсөв сар, улирлын хуваарийн санхүүжилтийн эрх дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-10 /2023-2025 оны батлагдсан төсөв, санхүүжилтийн эрх/

/Сая.төгрөг/

Д/д	Байгууллага, хөтөлбөрийн нэр	2023 он		2024 он		2025 он	
		Жилийн батлагдсан төсөв	Санхүүжилт ийн эрх өссөн дүнгээр	Жилийн батлагдсан төсөв	Санхүүжилт ийн эрх өссөн дүнгээр	Жилийн батлагдсан төсөв	Санхүүжилт ийн эрх өссөн дүнгээр
1	Аймгийн ИТХ	922.5	922.5	1,211.1	1,211.1	1,974.1	1,974.1
2	Аймгийн ЗДТГ	3,510.8	3,510.8	5,384.3	5,384.3	7,146.0	7,226.0
3	БОАЖГ	1,283.3	1,283.3	2,008.6	2,008.6	2,081.5	2,081.5



4	Худалдан авах ажиллагааны газар			372.5	372.5	477.5	477.5
5	СХДАА	270.4	270.4	442.0	442.0	494.1	494.1
6	ОНӨГ	286.1	286.1	290.8	290.8	513.2	513.2
7	Музей	27.7	27.7	20.8	20.8	29.8	29.8
8	Ойрад ХЖТ	289.9	87.1	96.7	96.7	842.4	842.4
9	Номын сан	66.9	66.9	109.4	109.4	121.7	121.7
10	Биеийн тамир спортын газар	348.9	348.9	498.0	498.0	654.3	674.3
11	Улаангом политехник коллеж	400.1	400.1	826.9	826.9	662.0	662.0
12	Нэгдсэн эмнэлэг			1,650.4	1,650.4	1,580.8	1,580.8
13	Авто замын сан	745.6	745.6	1,573.3	1,573.3	1,188.9	1,188.9
14	Халамжийн сан	831.7	831.7	188.1	188.1	491.4	491.4
15	Засаг дарга /Ахмадын хороо/	43.3	43.3	56.1	56.1	61.7	61.7
16	Засаг дарга /ХБИХХ/	34.6	34.6	39.2	39.2	40.6	40.6
17	Засаг дарга /ГБХЗХГ/	32.0	32.0	52.3	52.3	130.6	130.6
18	Эмнэлгийн тусламж үйлчилгээ			53.5	53.5	47.4	47.4
19	Засаг дарга /МЭҮ/	639.0	639.0	759.0	759.0	1,055.9	1,055.9
20	Засаг дарга гамшгаас хамгаалах	235.0	235.0	944.2	944.2	150.0	150.0
21	Засаг дарга /Өвсний нөөц/	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0
22	Засаг дарга /Махны нөөц/	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0
23	Засаг дарга /Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардал/	856.2	856.2	801.0	801.0	4,000.0	4,000.0
24	Хот байгуулалт, тохижилт			1,365.8	1,365.8		
25	Засаг дарга /БОХНСАХ/	22.7	22.7	60.5	60.5	12.1	12.1
26	Засаг дарга /Их засвар, ОНХО/	1,886.0	1,886.0	4,217.2	4,217.2	4,053.3	4,053.3
27	Үндсэн үйл ажиллагааны зардал /ОННэмэгдэл/			652.5	652.5	67.5	67.5
28	ОНТ-өөс УТБ-д олгох ОННэмэгдэл					716.0	716.0
29	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал			1,609.8	1,609.8	1,100.7	1,000.7
30	Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас			25.8	25.8	68.4	68.4
31	Зээлийн эргэн төлөлт	681.9	681.9				
	Дүн	13,814.6	13,611.9	25,709.8	25,709.8	30,161.9	30,161.9
1	Баруунтуруун	482.4	482.4	456.0	456.0	193.0	193.0
2	Бөхмөрөн	482.8	482.8	623.6	623.6	541.9	541.9
3	Давст	749.7	749.7	1,043.9	1,043.9	993.4	993.4
4	Завхан	716.0	716.0	880.8	880.8	816.4	816.4



5	Зүүнговь	757.9	757.9	1,018.6	1,018.6	912.1	912.1
6	Зүүнхангай	780.4	780.4	980.7	980.7	855.2	855.2
7	Малчин	746.7	746.7	963.3	963.3	983.8	983.8
8	Наранбулаг	842.6	842.6	984.9	984.9	883.2	883.2
9	Өлгий	768.9	768.9	1,059.0	1,059.0	931.7	931.7
10	Өмнөговь	854.0	854.0	909.8	909.8	569.1	569.1
11	Өндөрхангай	824.2	824.2	996.4	996.4	830.5	830.5
12	Сагил	700.9	700.9	1,001.5	1,001.5	845.7	845.7
13	Тариалан	949.2	949.2	1,083.2	1,083.2	901.9	901.9
14	Түргэн	854.3	854.3	1,169.7	1,169.7	1,079.3	1,079.3
15	Тэс	1,093.9	1,093.9	1,555.2	1,555.2	1,255.2	1,255.2
16	Ховд	686.0	686.0	886.4	886.4	799.7	799.7
17	Хяргас	704.4	704.4	1,015.5	1,015.5	902.2	902.2
18	Цагаанхайрхан	765.5	765.5	959.3	959.3	858.0	858.0
	Сумдын дүн	13,759.8	13,759.8	17,587.8	17,587.8	15,152.3	15,152.3
	Нийт дүн	27,574.4	27,371.7	43,297.6	43,297.6	45,314.2	45,314.2

/Эх сурвалж: Санхүүжилтийн эрх олгосон тайлан, мэдээ/

Ойрад хөгжимт жүжгийн театрт 2023 оны төсвийн хуваариар 289.9 сая төгрөг олгохоор баталсан ч 87.1 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгосон байна. Энэ нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн аймгийн хөгжимт драмын “Ойрад” театрын барилга /Увс, Улаангом сум/ төсөл, арга хэмжээг 2023 оны 4 дүгээр улиралд ашиглалтад хүлээн авахаар тооцож төсөв тусгасан боловч тухайн хөрөнгө ашиглалтад ороогүй тул 202.7 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгогдоогүй байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/541 дүгээр “Төсөвт зохицуулалт хийх тухай” захирамжаар аймгийн Засаг даргын ерөнхий дансны шинээр ашиглалтад орох барилга байгууламжийн байр ашиглалтын тогтмол зардлыг 100.0 сая төгрөгөөр бууруулан аймгийн Засаг даргын тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгийн зардалд 80.0 сая, Биеийн тамир спортын газрын урсгал засварын зардалд 20.0 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж санхүүжилтийн эрхийг олгосон байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6-д “Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох журам”, 2.6.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно”, 2.6.2-д “Аймаг, нийслэлийн Төрийн сан нь энэ журмын 2.4.9, 2.4.13-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг ажлын 2 өдөрт багтаан мөн журмын 24 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан сум, дүүргийн зохих дансанд хуваарилна” гэж тусгажээ.

Гэтэл улсын төсвөөс татаас авдаг аймгийн хувьд улсын төсвийн татаас санхүүжилт сар бүрийн 8-ны өдрөөс хойш санхүүжигддэг болон орон нутгийн орлого төвлөрүүлэлтээс хамаарч дээрх журмын цаглаварт хугацааг баримтлах боломжгүй байна. Төсвийн санхүүжилтийн эрх олголт нь орон нутгийн түвшинд татаас санхүүжилт болон төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалан сар бүр өөр өөр цаг хугацаанд олгогдож байна.

Мөн журмын 2.6.4-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төрийн сан нь төсвийн хуваарьт бууруулах өөрчлөлт орсон тухай бүрд санхүүжилтийн тооцоог хийж, энэ журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан төвлөрүүлнэ” гэж заасны дагуу тухай бүрд санхүүжилтийн тооцоог хийж, холбогдох маягтаар баталгаажуулан төвлөрүүлж ажилласан байна.



2.1.2. Төсвийн зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, зориулалт, эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцэж байгаа ч эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж төсвийн зарцуулалтын эрхийг 2025 онд бүрэн олгоогүй байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ” 37.1.8 дахь заалтад “Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох”, Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолын 1.1.4-т “Төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.1-т “Төрийн сан төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг Төсвийн тухай хуулийн 37.1.8-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн олгоно” гэж тус тус заасны дагуу Сангийн яамнаас төсөвт байгууллагуудын зарцуулах эрхийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу сар бүр олгож байна.

Мөн тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5-д “Төсвийн зарцуулалтын эрх олгох” гэж заасны дагуу дараах шаардлагыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- 5.1 Төв Төрийн сан улсын төсвийн байгууллагын зарцуулалтын эрхийг батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт багтаан зардлын бүлэг болон эдийн засгийн ангиллаар тухайн сарын ажлын эхний 5 өдөрт багтаан системд бүртгэж оруулна.
- 5.2 Орон нутгийн Төрийн сан нь орон нутгийн төсвийн байгууллага болон Төсвийн тухай хуулийн 15.2-д заасан төсвийн төвлөрүүлэн захирагчдын төсвийн байгууллагуудын зарцуулалтын эрхийг тухайн шатны Засаг даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийг үндэслэн тухайн сарын ажлын эхний 7 өдөрт багтаан системд бүртгэж оруулна.
- 5.3 Төрийн сангаас олгосон зарцуулалтын эрх Төсвийн тухай хуулийн 12.1.17, 34.3-т зааснаас бусад тохиолдолд төсвийн жилийн туршид хүчин төгөлдөр байна.
- 5.4 Төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна.

Харин Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Төсөвт дараах тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна” гэж заасны дагуу Сангийн яамнаас төсвийн зарцуулалтын эрхийн хязгаарлалт хийдэг байна. Үүнд:

- 6.1.1.нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;
- 6.1.2.нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;
- 6.1.3.нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;
- 6.1.4.Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.
- 6.3.Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй.
- 6.5.Энэ хуулийн 6.1.2-т заасан тусгай шаардлагын доод хэмжээг бууруулах, 6.1.4-т заасан тусгай шаардлагын дээд хэмжээг нэмэгдүүлэхийг хориглоно.
- 6.6.Энэ хуулийн 6.1.2-т заасан суурь тэнцлийн ашгийг Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахад зарцуулна.



Мөн Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэгт “Тухайн жилийн төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд дараах хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийг түр зогсоож болно”, 34.3.1 дэх заалтад “Санхүүжүүлэх хэмжээ нь багасахаар, эсхүл хасагдахаар төсвийн тодотголын төсөлд тусгасан”, 34.3.2 дахь заалтад “Тухайн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа гэрээ байгуулагдаагүй”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.2-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуулийн 12.1.17-д заасны дагуу төсвийн орлогын бүрдэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг бууруулах бүрэн эрхтэй байна”, 2.3-д “Тухайн жилийн төсөвт тодотгол хийж дуусах хүртэлх хугацаанд Төсвийн тухай хуулийн 34.3-т заасны дагуу холбогдох хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийг түр зогсоож болно” гэж тус тус заасан байна.

Дээрх хууль, журмын зохицуулалтын хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай” албан даалгаврын 2.6-д “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах” гэж заасантай уялдуулан Увс аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгавар гаргасны дагуу аймаг, сумдын төсөвт байгууллагууд албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэст хүргүүлэн, биелэлтийг дүгнэн ажилласан байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын 1.4-т “Тэвчиж болох дараах арга хэмжээ, зардлын санхүүжилтийг 2025 он дуустал хугацаанд зогсоож, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг хэмнэлттэй, үр ашигтай байдлаар зохион байгуулах” гэж заасан байна. Үүнд:

- Хурал, семинар, сургалтыг цахимаар зохион байгуулж, дотоод, гадаад томилолт, тээвэр шатахуун, зочин, төлөөлөгч хүлээн авах зардлыг хэмнэх;
- Байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох
- Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, бичиг хэргийн зүйлс худалдан авахгүй байх;
- Гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ шинээр байгуулахгүй байх;
- Төрийн байгууллагын хэрэгжүүлдэг хөтөлбөр, арга хэмжээний зардлын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх.

Дээрх албан даалгаврын дагуу 2025 онд аймгийн төсөвт байгууллагуудын тогтмол зардал болон бусад урсгал үйл ажиллагааны тэвчиж болох зардлын төсөв мөн аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлын төсөвт зарим сард зарцуулалтын эрх нээхгүйгээр хязгаарлалт хийснээс шалтгаалж төсөвт байгууллагуудад 2025 оны жил эцсийн санхүүгийн тайлангаар өр төлбөр үүссэн байна.

Харин Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.12-т “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох журам”, 2.12.1-т “Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна”, 2.12.2-т “Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр харьяалагдах Төрийн санд хүргүүлнэ”

гэж заасан байна. Үүнд:

- 2.12.2.1.Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу тухайн эх үүсвэрийг нотлох холбогдох тушаал, шийдвэр, гэрээ;
- 2.12.2.2.нэмэлт төсвийг зарцуулах тухай төсвийн захирагчийн шийдвэр болон бусад холбогдох шийдвэр;
- 2.12.2.3.энэ журмын 32 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулсан нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт.

Мөн тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 7-д “Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох”, 7.2-д “Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг нээлгэх хүсэлтийг HT№1 маягтын дагуу бэлтгэн дараах материалын хамт төв болон аймаг нийслэл, дүүргийн Төрийн санд албан бичгээр ирүүлнэ” гэж заасан байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 ба 47.1.2-т заасан эх үүсвэрийн холбогдох баримт бичиг;
- Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3 ба 47.1.4-т заасан эх үүсвэрийн төсвийн захирагчийн шийдвэр, гэрээ
- Нэмэлт төсвийг зарцуулах төсвийн захирагчийн баталсан төсөв, сарын хуваарь;
- Орлогын гүйлгээний хуулга.

Аймгийн санхүү, Төрийн сангийн хэлтэс нь дээрх журмын 7.2-д заасан баримт материалыг үндэслэн төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 2023-2025 онд зарцуулалтын эрхийг дараах байдлаар нээж олгосон байна. Үүнд:
График-4 /Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн нэгтгэл/



/Эх сурвалж: Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгосон баримтын түүвэр/


Дээрх графикаас үзэхэд төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 онд 70 байгууллагад 453 удаагийн зарцуулалтын эрхээр 9,407.4 сая, 2024 онд 57 байгууллагад 656 удаагийн зарцуулалтын эрхээр 14,951.2 сая, 2025 онд 54 байгууллагад 308 удаагийн зарцуулалтын эрхээр 10,488.1 сая төгрөгийн эрх тус тус нээж олгосон байна.

Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5-д “Зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх” гэж заасны дагуу аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь төсөвт байгууллагуудын албан бичгээр ирүүлсэн төсвийн зардлын зохицуулалт хийлгэх саналыг үндэслэн хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэн ажилласан байна.



Тухайлбал: 2023 онд 25 байгууллагаас 34 удаагийн хүсэлтээр 347.9 сая, 2024 онд 20 байгууллагаас 29 удаагийн хүсэлтээр 964.3 сая, 2025 онд 42 байгууллагаас 63 удаагийн хүсэлтээр 980.3 сая төгрөгийн төсвийн зардлын зохицуулалтын саналыг тус тус шийдвэрлэсэн байна.

График-5 /Төсөвт байгууллагуудын зардлын зохицуулалт/



/Эх сурвалж: Төсөвт байгууллагуудын зардлын зохицуулалтын баримтын түүвэр/

2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажуулж, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байгаа ч зарим төрлийн зөрчлийг давтан гаргасаар байна.

2.2.1. Аймгийн Төрийн сангаар харилцдаг улсын төсвийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгааг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу тулган, хянаж баталгаажуулж байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.24-т "Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа Төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна" гэж заасан байна.

Аймгийн Төрийн сангаар харилцдаг улсын төсвийн болон орон нутгийн төсөвт байгууллагуудаас дансны үлдэгдлийн баталгааг Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тулган, хянаж баталгаажуулан архивын нэгж болгон хадгалсан байна. Үүнд:

Хүснэгт-11 /Төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгаа/

№	Байгууллагын нэр	Дансны тоо 2023 он	Дансны тоо 2024 он	Дансны тоо 2025 он
1	Шүүхийн Тамгын газар	3	3	3
2	Прокурорын газар	2	2	2
3	Стандарт хэмжил зүйн хэлтэс	2	2	2
4	Тагнуулын газар	2	2	2
5	Татварын хэлтэс	2	2	2
6	Гаалийн газар	1	2	2
7	Цагдаагийн газар	3	3	3
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар	2	2	2
9	Хилийн цэргийн 0245-р анги	2	2	2



10	Шүүх шинжилгээний хэлтэс	2	2	2
11	Улсын бүртгэлийн хэлтэс	3	3	3
12	Байгаль орчин аялал жуулчлалын газар	2	2	2
13	Увс нуур ай сав улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа	2	2	2
14	Увс нуур тэс голын сав газрын захиргаа	2	2	2
15	Ус цаг уур орчны шинжилгээний төв	2	2	2
16	Боловсролын газар	2	2	2
17	Биеийн тамир спортын газар	3	4	3
18	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар	2	2	2
19	Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газар	2	2	2
20	Хүнс хөдөө аж ахуйн газар	2	2	2
21	Мал эмнэлгийн газар	1	2	2
22	Эрүүл мэндийн газар	2	2	2
23	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	2
24	Зооноз өвчин судлалын төв	2	2	2
25	Төрийн Аудитын газар	2	2	2
26	Статистик хэлтэс	2	2	2
27	ГХБХБГ	3	2	2
28	Онцгой байдлын газар	2	2	2
29	Музей	3	2	2
30	Аймгийн хөгжимт жүжгийн театр	3	2	2
31	Номын сан	3	2	2
32	Улаангом политехник коллеж	3	2	2
33	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	2	2
34	Аймгийн Засаг даргын тамгын газар	2	2	2
35	Санхүүгийн хяналт дотоод аудитын газар	2	2	2
36	Орон нутгийн өмчийн газар	2	2	2
37	Нийгмийн даатгалын газар	2	2	2
38	Соёл урлагийн газар	2	2	2
39	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	2	2
40	Халамжийн сан	1	1	1
Нийт		86	84	83

/Эх сурвалж: Төсөвт байгууллагуудын дансны үлдэгдлийн баталгааны архивын баримт/

2.2.2. Төрийн сан, төсвийн байгууллага бүртгэлийн дансны төлбөр тооцоо, төлбөрийн хүсэлт, зарлагын гүйлгээг хийхдээ зарим төрлийн зөрчлийг давтан гаргасаар байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.2 дахь заалтад “Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх”, 37.1.3 дахь заалтад “Төсвийн хяналтыг зардлын бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх”, 37.1.5 дахь заалтад “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих” гэж заажээ.

Аймаг, сумдын Төрийн сангаас төсөвт байгууллагуудын гүйлгээнд Төрийн сангийн удирдлагын цахим системээр дамжуулан баталгаажуулалт, хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Аудитаар Улаангом сум болон хөдөөгийн 5 сум, нийт 6 суманд очиж ажилласан бөгөөд бусад 13 сумдын хувьд холбогдох баримт материалыг татан авч түүвэр байдлаар хяналтыг хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийтлэг зөрчил болон Санхүү, Төрийн сангийн хэлтсээс Төрийн сангийн 2023-2025 оны үйл ажиллагаанд хийсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн нийтлэг алдаа зөрчил, өгсөн зөвлөмжийг тайлангийн 2 дугаар бүлгийн 2.3 дахь хяналтын тогтолцооны хэсэгт тусгасан бөгөөд аудитаар гарсан илрүүлэлтээр давхардуулан тусгахгүйгээр зөвлөмжийн биелэлт, хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтийг түүвэр байдлаар давтан хянаж баталгаажуулсан болно.

Тулган баталгаажуулалтаар дараах зөрчлүүд зарим сум, байгууллагад давтан гарч байна. Тухайлбал:

- Төрийн сангийн удирдлагын цахим системд бүрдэл дутуу, шаардлага хангаагүй анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн. Тухайлбал: цалингийн гүйлгээнд цагийн баланс хавсаргаагүй, албан томилолтын гүйлгээнд илтгэх хуудас, хөтөлбөр хавсаргаагүй, томилолтын хуудсыг хаагаагүй, орлого, зарлагын баримтын гарын үсэг, тамга тэмдэг дутуу, ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлын гэрээг хавсаргаагүй, баримтын эх хувийг цахимд оруулаагүй, гараар засвар хийсэн, хяналтын хуудсанд анхан шатны баримтын бүрдлийг дутуу шивж оруулсан, хамааралгүй файл хавсаргаж гүйлгээ хийсэн, сканердсан баримт шаардлага хангахгүй байх гэх мэт.
- Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллыг зөрүүлж гүйлгээ хийсэн.
- Тооцооны үлдэгдлийн баталгаагаар тооцоо нийлж баталгаажуулаагүй гүйлгээ хийсэн.
- Байгууллагын нярвын дансаар дамжуулан гүйлгээ хийсэн.
- Санхүүгийн албаны дарга нь төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг хавсран гүйцэтгэсэн, төсөв Төрийн сангийн мэргэжилтний эрхээр нууц үгээ дамжуулж гүйлгээ хянасан.
- Эрхийн бүртгэлийн санд 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэр, гарын үсгийн баталгаа, цахим мэдэгдэл, зарим байгууллагуудын нягтлан бодогчдын сонгон шалгаруулалтын болон зөвшилцсон бичгийг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 294 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу шинэчлэн бүрдүүлээгүй.
- Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээг цахим системд шивж баталгаажуулаагүй гэх мэт.

Мөн аймаг, сумдын төрийн сангийн 2023-2025 оны нийт гүйлгээнээс тогтмол зардлын гүйлгээнд түүврийн аргаар хяналт хэрэгжүүлэхэд эдийн засгийн ангилал зөрчиж нийт 95.4 сая төгрөгийн 94 гүйлгээг хийсэн байна. Үүнд:

Хүснэгт-12 /Тогтмол зардлын гүйлгээнд хийсэн түүврээр илэрсэн зөрчил/

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 он	
		Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн төрийн сан	9	1,074.4	2	339.8	5	13,575.9
2	Давст сум	5	4,699.0	2	2,287.6	3	12,912.4
3	Завхан сум			3	3,865.0		
4	Зүүнговь сум					3	459.1
5	Зүүнхангай сум					1	99.1
6	Малчин сум					1	415.0



7	Наранбулаг сум	10	9,076.6	4	1,304.7	7	9,085.8
8	Өлгий сум	1	143.0			3	10,747.9
9	Өндөрхангай сум	1	108.9			1	27.1
10	Тариалан сум			1	181.8	1	600.0
11	Түргэн сум					2	202.4
12	Тэс сум	1	500.0			3	3,648.3
13	Ховд сум					1	342.2
14	Хяргас сум			5	1,023.1		
15	Цагаанхайрхан сум			6	4,406.3	7	6,064.6
16	Улаангом сум	2	2,961.2	3	4,034.2	1	1,259.6
Нийт		29	18,563.2	26	17,442.5	39	59,439.5

/Эх сурвалж: Тогтмол зардлын түүвэр тулгалт/

Дээрх хүснэгтээс харахад Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”-ыг зөрчиж 2023 онд 18.6 сая төгрөгийн 29 гүйлгээ, 2024 онд 17.4 сая төгрөгийн 26 гүйлгээ, 2025 онд 59.4 сая төгрөгийн 39 гүйлгээг тус тус хийсэн байна.

Тухайн зөрчлийг утгаар нь авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Гэрэл цахилгааны зардлаас түлш халаалт, гэрэл цахилгааны ашиглалттай холбоотой гарсан засвар үйлчилгээний ажлын зардал, интернэт шуудан холбооны зардал, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс гэх мэт
- Түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардал
- Цэвэр, бохир ус зардлаас цэвэр, бохир ус ашиглахтай холбоотой гарсан засвар үйлчилгээний ажлын зардал, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, ус бохирдуулсны болон усны шинжилгээний төлбөр хураамж гэх мэт зардлыг гаргасан байна.

Дээрх зөрчил гарсан аймгийн болон сумдын төрийн санд дотоод хяналт хэрэгжүүлэн зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажиллах зөвлөмжийг эрх бүхий албан тушаалтанд өглөө.

Түүнчлэн аймаг, сумдын төрийн сангууд тогтмол зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 2023-2025 онд хийсэн нийт 73.2 сая төгрөгийн 13 гүйлгээг тухайн үед нь залруулсан байна. Үүнд:

Хүснэгт-13 /Тогтмол зардлын түүврээр тухайн үед залруулсан гүйлгээ/

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2023 он		2024 он		2025 он	
		Гүйлгээ ний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн төрийн сан	1	140.7	1	57,620.0		
2	Зүүнхангай сум			2	198.0		
3	Малчин сум					1	892.4
4	Өмнөговь сум			1	4,459.3		
5	Ховд сум			1	2,998.1		
6	Улаангом сум	2	1,429.9	3	3,047.5	1	2,453.4
Нийт		3	1,570.6	8	68,322.9	2	3,345.8

/Эх сурвалж: Тогтмол зардлын түүвэр тулгалт/



Дээрх хүснэгтээс харахад 2023 онд 1.6 сая төгрөгийн 3 гүйлгээ, 2024 онд 68.3 сая төгрөгийн 8 гүйлгээ, 2025 онд 3.3 сая төгрөгийн 2 гүйлгээг тус тус эдийн засгийн ангилал зөрчиж хийснийг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4-р хавсралтаар баталсан маягтын дагуу тухайн үед нь залруулсан байна.

Цаашид төрийн сангаар гүйлгээ хийх тухай бүрд тавих шат шатны хяналтыг сайжруулж ажиллахыг зөвлөлөө.

2.2.3. Бүртгэлийн дансны тодорхойгүй орлого, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулан буцаасан тохиолдол гараагүй байна.

Аймаг, сумдын Төрийн санд 2023-2025 онд бүртгэлийн дансны тодорхойгүй орлого байхгүй, буцаалтыг журмын дагуу дансанд байршуулж, холбогдох баримтыг үндэслэн гүйлгээг залруулсан тохиолдол гараагүй байна.

Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/9469 дүгээр “Хамтран ажиллах тухай” албан бичгийн 5-д “Арилжааны банкин дахь ашиглалтгүй байгаа дансыг хаах, үлдэгдэлтэй байгаа нөхцөлд Улсын төсвийн 100900000707 дугаартай данс уруу төвлөрүүлж, данс хаасан мэдээллийг ирүүлэх” чиглэл ирүүлсэн байна. Уг чиглэлийн дагуу төвлөрүүлсэн орлого байхгүй байна.

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнаж байна.

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтад “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана”, 8.9 дэх хэсэгт “Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, орон нутгийн төсвийн улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглаврын дагуу боловсруулна”, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т “Төсвийн гүйцэтгэлийн тайлан, түүний тохируулга”, 4.2.1-т “Төсвийн байгууллага нь төсвийн гүйцэтгэлийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу гаргасан мөнгөн гүйлгээний тайлангаас тохируулга хийх замаар гаргаж, энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтаар гаргасан тохируулгын тайлангийн хамт дээд шатны төсвийн захирагчид Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлнэ”, 4.2.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтаар, тохируулгын тайланг мөн журмын 10 дугаар хавсралтад заасан маягтаар, төсвийн гүйцэтгэлийн зарлагын нэгтгэлийг мөн журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтаар тус тус гарган төв Төрийн санд Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлнэ” гэж заасны дагуу тайлан, мэдээг гаргаж хүргүүлсэн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтад “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг хэрэгжүүлэн төсвийн шууд захирагчид төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг улирал бүр хуулийн хугацаандаа гаргаж харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин жил эцсийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Увс аймаг дахь Төрийн аудитын газарт болон харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.



- Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтад “Төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчид төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хагас, бүтэн жилээр гарган тайлагнасан байна. Харин жил эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд гаргаж Увс аймаг дахь Төрийн аудитын газарт болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.
- Төсвийн тухай хуулийн 8.9.5 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хагас, бүтэн жилээр гарган Сангийн яаманд тайлагнасан байна. Харин жил эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд гаргаж Увс аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж, аудитын тайланг болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 8.8 дахь хэсэгт “Улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглаврын дагуу боловсруулж, батална” гэж заасан байна. Үүнд:

- 8.8.1.төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх
- 8.8.2.төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 04-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;
- 8.8.3.төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 06-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- 8.8.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 08-ны дотор нэгтгэн гаргах;

“Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7-д “Орон нутгийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ боловсруулах” гэж заажээ. Үүнд:

- 4.7.1.Орон нутгийн төсвийн байгууллага төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг төсвийн тухай хуулийн 8.8.1-д заасны дагуу харьяалагдах төсвийн захирагчид хүргүүлнэ;
- 4.7.2.Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний орлогын залруулгыг сар бүрийн 02-ны өдрийн дотор энэ журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу төсөвт байгууллагаас ирүүлсэн хүсэлтээр Төрийн сангийн холбогдох системд залруулах бичилт хийнэ
- 4.7.3.Орон нутгийн төсвийн орлогыг орлогын нэр төрөл болон орлого төвлөрүүлэгч байгууллагаар тооцоо нийлж баталгаажуулан санхүүжилт олгох ерөнхий орлогын дансанд ангилан бүртгэнэ;
- 4.7.4.Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг нэгтгэн боловсруулахад дараах шаардлагыг хангасан байна
- 4.7.4.1.орон нутгийн төсвийн санхүүжилт нь орон нутгийн төсөвт байгууллагуудын төсвөөс санхүүжих эх үүсвэртэй тэнцүү
- 4.7.4.2.энэ журмын 4.5.4-т заасан орон нутгийн төсөвт олгосон шилжүүлгийн дүн орон нутгийн төсвийн орон нутгийн хөгжлийн сан, санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэртэй тэнцүү
- 4.7.4.3.аймаг, нийслэлээс сум, дүүрэгт олгосон санхүүгийн дэмжлэг, сум, дүүргээс аймаг, нийслэлд төвлөрүүлэх шилжүүлгийг төсвийн хуваарьт оруулан тайлагнана.

Увс аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын Төрийн сан нь төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг Төсвийн тухай хуулийн 8.8 дахь хэсэг, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7-д тус тус заасны дагуу дээд шатны төсвийн захирагчид хүргүүлдэг бөгөөд Сангийн яам нь Засгийн газрын санхүүгийн



удирдлага мэдээллийн системийн И-Хуулга дэд системээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь нэгтгэдэг байна.

Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн И-Хуулга дэд системээс аль ч төсвийн захирагчийн мэдээг Сангийн яамнаас шууд татах, харах, мэдээ боловсруулах боломжтой байх тул шат дараалсан тайлагналын зохицуулалт нь практик хэрэгжилтийн хувьд ач холбогдолгүй байна. Иймд цаасаар боловсруулж байгаа төсвийн гүйцэтгэлийн мэдээг авахгүй байх талаар холбогдох хууль, тогтоомж, журамд өөрчлөлт оруулахыг Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулах санал хүргүүлээ.

"Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Төсөв хоорондын тооцооны тайлан, мэдээ боловсруулах" гэж заажээ. Үүнд:


- 4.1.1.Бүх шатны төсвийн захирагч нь тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд төсвөөс авсан санхүүжилт, буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн тооцоог төсөв хоорондын тооцооны тайлангаар гаргана.
- 4.1.2.Бүх шатны төсвийн захирагч нь тухайн жилд урсгал санхүүжилтээс буцаан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг улсын төсвийн орлогод тооцох, нэр данс зөрүү, өглөгт тооцож төвлөрүүлсэн, санхүүжилтээс хасагдах дүн тус бүрээр энэ журмын 12 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, заасан хугацаанд хүргүүлнэ.
- 4.1.3.Өөрийн үйл ажиллагааны орлогоороо санхүүждэг төсвийн байгууллага нь төсвийн жил хоорондын тооцоог өөрийн орлогоос төвлөрүүлсэн болон улсын төсвийн орлогод тооцон төвлөрүүлсэн бусад орлого гэж ангилан хүргүүлнэ.
- 4.1.4.Төсөв хоорондын тооцооны тайланг төв Төрийн сан болон төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүү, хөрөнгө оруулалт, Төрийн сангийн нэгж нэгтгэнэ.
- 4.1.5.Төв Төрийн сан нь тухайн жилд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөөс төсөв хоорондын тооцооны тайлангаар гарсан өглөгт тооцох дүнг тооцоо нийлсэн актын холбогдох шийдвэрийг үндэслэн төсвийн дараагийн жилд багтаан тухайн шатны төсвийн захирагчийн бүртгэлийн дансанд буцаан олгоно.
- 4.1.6.Төсөв хоорондын тооцооны тайланг дараах хугацаанд боловсруулна.

Тус журмын 4.1.6-д "Төсөв хоорондын тооцооны тайланг дараах хугацаанд боловсруулна" гэж заажээ. Үүнд:

- 4.1.6.1.төв Төрийн сан нь төсөв хоорондын тооцооны тайланг төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлэх ба эхний хагас жилийн тайланг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- 4.1.6.2.төсвийн ерөнхийлөн захирагч нь эхний хагас жилийн төсөв хоорондын тооцооны тайланг жил бүрийн 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлнэ.
- 4.1.6.3.төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсөв хоорондын тооцооны тайланг төсвийн шууд захирагч тус бүрээр тулган баталгаажуулж, албажуулан төсвийн ерөнхийлөн захирагчид эхний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.
- 4.1.6.4.төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хоорондын тооцоог тулган баталгаажуулж, албажуулан эхний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 05-ний өдрийн дотор төв Төрийн санд хүргүүлнэ.

Дээрх журмын хүрээнд Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хоорондын тооцоог тулган баталгаажуулан жил эцсийн санхүүгийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Үүнд:

График-6 /Улсын төсөв хоорондын тооцоо 2023-2025 оны харьцуулалт/



/Эх сурвалж: Төсөв хоорондын тооцоо/

Графикаас үзэхэд 2023 онд санхүүгийн дэмжлэгээр 20,498.1 сая, ОНХС-ийн шилжүүлэг 11,080.4 сая, нийт 31,578.5 сая, 2024 онд санхүүгийн дэмжлэгээр 30,877.0 сая, ОНХС-ийн шилжүүлэг 12,546.3 сая, нийт 43,423.3 сая төгрөг, 2025 онд санхүүгийн дэмжлэгээр 28,342.1 сая, ОНХС-ийн шилжүүлэг 10,680.6 сая, нийт 39,022.7 сая төгрөгөөр тус тус төсөв хоорондын тооцоог нийлсэн байна.

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо дахь дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

2.3.1. Санхүү, Төрийн сангийн хэлтсээс 2023-2025 онд нийт 18 суманд төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 суманд буюу 33.3 хувьд нь дотоод хяналтыг, 3 сумын Төрийн санд төлөвлөгөөт бус дотоод хяналтыг хэрэгжүүлсэн ч зөрчил давтагдан гарсаар байна.

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 12.1.6 дахь заалтад “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, 12.1.16-д “төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, 14.2.10 дахь заалтад “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэгт “Төв Төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын Төрийн сан болон Төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын Төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Мөн Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.1-д “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 36.6-д заасны дагуу хэрэгжүүлэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврыг мөрдлөг болгоно”, 3.9.4-д “Төв Төрийн сан энэ журмын 3.9.3.1-д заасан дотоод хяналт хийх төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр,



удирдамжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн даргаар тус тус батлуулан мөрдөж ажиллана; 3.9.5-д “Аймаг, нийслэлийн Төрийн сан энэ журмын 3.9.3.1-д заасан дотоод хяналт хийх төлөвлөгөөг Засаг даргаар, удирдамжийг санхүү, Төрийн сангийн хэлтсийн даргаар тус тус батлуулан мөрдөж ажиллана”, 3.9.6-д “Энэ журмын 3.9.3.2-т заасан дотоод хяналтыг шаардлагатай тохиолдолд зорилтот Төрийн сангийн үйл ажиллагаанд хийх бөгөөд төв Төрийн сан төлөвлөгөөт бус хяналтын төлөвлөгөөг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр, аймаг, нийслэлийн Төрийн сан нь Засаг даргын шийдвэрээр батлуулан баг томилон ажиллуулна”, 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны Төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ”, 3.9.8-д “Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан жил бүрийн эхэнд Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх зааварт заасны дагуу үнэлж, удирдлагадаа танилцуулна” гэж тус тус заасан байна.

Тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4.3-д “Төлөвлөгөөт хяналтыг хийх календарчилсан төлөвлөгөөг жил бүрийн эхний улиралд багтаан Төв Төрийн сан Сангийн сайдаар, аймаг нийслэлийн Төрийн сан Засаг даргаар тус тус батлуулан мөрдөнө” гэж заасны дагуу Монгол улсын Сангийн сайдын “Төлөвлөгөө батлах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 15 дугаар тушаалыг хүчингүй болгож 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 103 дугаар “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Төв Төрийн сангаас Увс аймгийн санхүү, Төрийн сангийн хэлтсийн 2022, 2023 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийсэн байна.

Хяналт шалгалтаар “Санхүү, төрийн сангийн хэлтсийн ажлын ачаалал их, Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлж, төсөвт байгууллагууддаа зөвлөгөө тусламж үзүүлэн ажилласан байна” гэж дүгнэжээ. Мөн “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 3 дугаар хавсралтаар баталсан санал асуулгад 20 төсөвт байгууллагын нягтлан бодогч хамрагдсанаас 19 төсөвт байгууллага буюу 95 хувь нь Төрийн сангийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун гэж дүгнэсэн байна.

Хяналт шалгалтаар Увс аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нийт 16 зөвлөмж өгсөн байна. Мөн Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын дагуу эрсдэлийн үнэлгээ хийхэд эрсдэлийн түвшин “**Бага**” үнэлгээтэй гарч, тухайн Санхүү, төрийн сангийн хэлтсийн үйл ажиллагаа нь хууль, журмын хүрээнд явагдаж байгааг харуулж байна гэж дүгнэсэн байна.

Дээрх дотоод хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг сум, байгууллагаар нь гарган нэгтгэж аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсийн 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 7/1973 дугаар бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Харин 2024, 2025 онд Төв Төрийн сангаас төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгээгүй байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4.3-д “Төлөвлөгөөт хяналтыг хийх календарчилсан төлөвлөгөөг жил бүрийн эхний улиралд багтаан Төв Төрийн сан Сангийн сайдаар, аймаг нийслэлийн Төрийн сан Засаг даргаар тус тус батлуулан мөрдөнө” гэж заасны дагуу төлөвлөгөөг баталсан



байна. Үүнд:

- ❖ Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/22 дугаар захирамжаар “2023 онд сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөө”-нд Давст, Сагил, Түргэн, Тэс, Зүүнговь, Баруунтуруун гэсэн 6 сумын Төрийн сангийн үйл ажиллагааг хамруулахаар календарчилсан төлөвлөгөөг баталсан байна.
- ❖ Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар “2024 онд сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөө”-нд Наранбулаг, Завхан, Ховд, Тэс, Хяргас, Цагаанхайрхан, Сагил гэсэн 7 сумын Төрийн сангийн үйл ажиллагааг хамруулахаар календарчилсан төлөвлөгөөг баталсан байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4.5-д “Энэхүү журмын 4.1.2, 4.1.3-т заасны дагуу шалгалтыг хэрэгжүүлэхдээ тухайн байгууллагын Төрийн сангийн газрын дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулна” гэж заажээ.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2023 онд сумдад дотоод хяналт хийх удирдамж батлаагүй, төлөвлөгөөт дотоод хяналт хийгээгүй, харин 2024 онд сумдад дотоод хяналт хийх удирдамжийг аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 7 сумдаас Ховд, Хяргас гэсэн 2 сумын Төрийн санд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 4.4-д “Төлөвлөгөөт бус хяналтыг шаардлагатай тохиолдолд тухайн зорилтот Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг Төв Төрийн сан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын, аймаг, нийслэл Засаг даргын шийдвэрээр баг томилон ажиллуулж болно” гэж заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс төлөвлөгөөт бус дотоод хяналтыг 2023 онд хийгээгүй бөгөөд 2024 онд Бөхмөрөн, Өлгий, Малчин гэсэн 3 сумын Төрийн санд хийсэн байна. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсэг томилсон аймгийн Засаг даргын шийдвэр байхгүй байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2024 онд сумдын Төрийн санд хийсэн дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчилд зөвлөмж өгч биелэлтийг гаргуулсан байна. Үүнд:

- ❖ Төрийн сангийн удирдлагын цахим системээр хийж буй гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангах
- ❖ Эрхийн бүртгэлийн санд 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэр, гарын үсгийн баталгаа, цахим мэдэгдэл, зөвшилцсон бичгийг бүрэн шинэчлэн оруулах
- ❖ Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хянаж баталгаажуулах
- ❖ Системийн хэрэглэгчийн эрхийг зөв олгож байнга хяналт тавьж ажиллах
- ❖ Цахим архивын нэгжийг архивын тухай хууль журмын хүрээнд хүлээлгэн өгч хэвших
- ❖ Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу баримт материалыг бүрэн хүлээн авч, барьцаа 5 хувь суутган тооцож ажиллах
- ❖ Төсвийн байгууллагын тээвэр шатахуун, халаалтын өрийг төсвийн боломжид тулгуурлан шийдвэрлэх
- ❖ Төсвийн байгууллагуудын 2024 оны 3 дугаар улирлын тайланг санхүүгийн тайлангийн Э-тайлан системд хугацаанд нь оруулах
- ❖ Шилэн дансны мэдээллийн сар бүр шаардлага хангасан мэдээлэл хугацаандаа бүрэн оруулж байх

Мөн Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын 5.3-д “Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг журмын 5.1-д заасны дагуу үнэлэн сум, дүүргийн төрийн сан аймаг, нийслэлийн төрийн санд дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор, Аймаг нийслэл, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сан Төв төрийн санд дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ” гэж заасны дагуу эрсдэлийн үнэлгээг сумдаар гаргуулан төрийн



сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын нэгдүгээр хавсралт маягтаар үнэлж, тус зааврын гуравдугаар хавсралт маягтаар нэгтгэн хүргүүлжээ.

Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын 4.2-д “Төлөвлөгөөт дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийг тухайн оны эхний улиралд багтаан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.4, 3.9.5-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулна” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/57 дугаар захирамжаар “2025 онд сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөө”-нд Наранбулаг, Тэс, Зүүнговь, Давст, Түргэн гэсэн 5 сумын Төрийн сангийн үйл ажиллагааг хамруулахаар календарчилсан төлөвлөгөөг баталсан байна.

Ингэхдээ Түргэн, Давст, Зүүнговь, Тэс сумдад ажиллах удирдамжийг аймгийн ЗДТГ-ын дарга баталсан байна. Дотоод хяналт хийх удирдамжид орсон Зүүнговь суманд дотоод хяналт хийгээгүй байна.

Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс 2025 онд сумдын Төрийн санд хийсэн дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчилд зөвлөмж өгч биелэлтийг гаргуулсан байна. Үүнд:

- ❖ Түргэн сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 18 төрлийн зөрчил илрүүлж, 8 зөвлөмж өгсөн байна.
- ❖ Тэс сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 25 төрлийн зөрчил илрүүлж, 8 зөвлөмж өгсөн байна.
- ❖ Наранбулаг сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 24 төрлийн зөрчил илрүүлж, 9 зөвлөмж өгсөн байна.
- ❖ Давст сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 17 төрлийн зөрчил илрүүлж, 8 зөвлөмж өгсөн байна.

Нийтлэг илэрсэн зөвлөмжийг утгаар авч үзвэл дараах байдалтай байна:

- Төрийн сангийн удирдлагын цахим системээр хийж буй гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангах
- Эрхийн бүртгэлийн санд 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэр, гарын үсгийн баталгаа, цахим мэдэгдэл, зөвшилцсон бичгийг бүрэн шинэчлэн оруулах
- Системийн хэрэглэгчийн эрхийг зөв сонгож, байнга хяналт тавих
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу баримт материалыг бүрэн хүлээн авч, барьцаа 5 хувь суутган тооцож ажиллах
- Цахим архивын нэгжийг хууль, журмын хүрээнд хүлээлгэн өгөх, цаашид хэвшүүлэх
- Өр, авлагын мэдээг сар бүр тулган баталгаажуулж системд үнэн зөв бүртгэж байх
- Татварын орлогын мэдээний зөрүүг арилгаж, санхүүгийн албаны болон татварын албанаас хамаарч буй зөрчлийг тухай бүр шийдвэрлэж байх
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх зааврын дагуу хэрэглэгчийн эрхээ шилжүүлэх, цаашид хэвшүүлэх
- Эх үүсвэр буюу санхүүжилт бууруулж гүйлгээ хийхгүй байх
- Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тулган баталгаажуулж, системд үнэн зөв бүртгэн, татварын орлого болон төсөвт байгууллагуудын орлогыг сар бүр хаах
- Цахим сургалтын системээрээ нэвтэрч ТСУЦСистемийн гарын авлага, цахим хичээлүүдээ тогтмол судалж хэвших

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын 4.3-д “Төлөвлөгөөт бус дотоод хяналт хийх шаардлага үүсвэл “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.6-д заасны дагуу төлөвлөгөө, удирдамжийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж, дотоод хяналт хэрэгжүүлэх баг томилон дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөт бус дотоод хяналт хийх шаардлагагүй гэж үзвэл мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана” гэж заасан байна. Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс 2025 онд төлөвлөгөөт бус дотоод хяналт хийгээгүй байна.



Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2023, 2024, 2025 онуудад хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчил нь сум байгууллага бүрд нийтлэг байна. Иймд илэрсэн зөрчил, анхаарах асуудлын талаарх мэдээллийг сум, байгууллагад бүрэн хүргэж, зөрчил давтагдан гарах эрсдэлийг бууруулж ажиллахыг зөвлөлөө.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс дотоод хяналт шалгалтыг 2023 онд 6 суманд хийхээр төлөвлөсөн ч хийгээгүй, 2024 онд 7 суманд хийхээр төлөвлөж 2 суманд хийсэн, 2025 онд 5 суманд хийхээр төлөвлөж 4 суманд хийсэн байна. Эндээс үзэхэд 2023-2025 онд нийт 18 суманд төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 суманд буюу 33.3 хувьд нь дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Цаашид төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, төлөвлөгөөнд тусгагдсан сумдад хяналт шалгалтыг хийж ажиллах зөвлөмж өглөө.

Мөн 2023, 2025 онд төлөвлөгөөт бус дотоод хяналт хийгдээгүй бөгөөд 2024 онд 3 сумын Төрийн санд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхдээ ажлын хэсэг томилсон аймгийн Засаг даргын шийдвэр байхгүй байна.

Цаашид төлөвлөгөөт бус дотоод хяналт хийхдээ Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын 4.3-д заасны дагуу төлөвлөгөө, удирдамжийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж, дотоод хяналт хэрэгжүүлэх баг томилон дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөлөө.

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын 8.1-д “Аймаг, нийслэлийн төрийн сан нь дотоод хяналтын нэгтгэсэн тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн шатны Засаг даргад танилцуулж, энэ зааврын хавсралт 8-д заасан дотоод хяналтын тайлангийн загварын дагуу нэгтгэн, энэ зааврын хавсралт 9-д заасан зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, эрсдэлийн үнэлгээний нэгтгэлийн хамт төв төрийн санд дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ” гэж заасны дагуу гаргаж Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна. Үүнд:

- ✓ Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 07/53 дугаар бичгээр 2023 онд хийсэн дотоод хяналтын тайланг,
- ✓ Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 7/138 дугаар бичгээр 2024 онд хийсэн дотоод хяналтын тайланг,
- ✓ Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 8/112 дугаар бичгээр 2025 онд хийсэн дотоод хяналтын тайланг тус тус хүргүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/75 дугаар захирамжаар баталсан дотоод хяналтын төлөвлөгөө, аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 7 суманд дотоод хяналт хэрэгжүүлэхээр тусгаснаас 2026 оны 5 сарын байдлаар Улаангом, Сагил, Баруунтуруун, Зүүнговь гэсэн 4 сумын Төрийн сангийн 2025 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2026 онд сумдын Төрийн сангийн 2025 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн дараах зөрчилд зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- ❖ Улаангом сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 6 төрлийн зөрчил илрүүлж, 7 зөвлөмж өгсөн байна.
- ❖ Баруунтуруун сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 15 төрлийн зөрчил илрүүлж, 8 зөвлөмж өгсөн байна.
- ❖ Зүүнговь сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 8 төрлийн зөрчил илрүүлж, 5 зөвлөмж өгсөн байна.
- ❖ Сагил сумын Төрийн сангийн үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналтаар 13 төрлийн зөрчил илрүүлж, 11 зөвлөмж өгсөн байна.



Нийтлэг илэрсэн зөвлөмжийг утгаар авч үзвэл дараах байдалтай байна: Үүнд:

- ❖ Төрийн сангийн удирдлагын цахим системээр хийж буй гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангаж, хууль, журам, зааврыг хэрэгжүүлэх.
- ❖ Эрхийн бүртгэлийн санд 1, 2-р гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэр, гарын үсгийн баталгаа, цахим мэдэгдэл, зөвшилцсон бичгийг бүрэн шинэчлэн оруулах.
- ❖ Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хянаж баталгаажуулах.
- ❖ Системийн хэрэглэгчийн эрхийг зөв олгож байнга хяналт тавьж ажиллах.
- ❖ Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдыг хууль, журмын хүрээнд сонгон шалгаруулалт зарлаж, зөвшилцөн томилж байх.
- ❖ Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Засгийн газрын 278 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу баримт материалыг бүрэн хүлээн авч, санхүүжилтийг олгох, журмыг хэрэгжүүлэн ажиллах.
- ❖ Цахим архивын нэгжийг хууль, журмын хүрээнд хүлээлгэн өгөх, цаашид хэвшүүлэх.
- ❖ Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тулган баталгаажуулж, системд үнэн зөв бүртгэн, татварын орлого болон төсөвт байгууллагуудын орлогыг сар бүр хаах.
- ❖ Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх зааврын дагуу хэрэглэгчийн эрхээ шилжүүлж, цаашид хэвшүүлэх.
- ❖ Албан дарга мэргэжилтэн хавсран ажилласан зөрчил арилгаж журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.
- ❖ Гүйцэтгэлээр санхүүждэг байгууллага буюу сургууль, цэцэрлэгийн гүйлгээг хийхдээ Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллах.
- ❖ Засаг даргын тамгын газраас бусад хөрөнгийн зардалд батлагдсан төсвийг хууль, журмын хүрээнд хяналт тавьж зарцуулж байх.
- ❖ Өр авлагын мэдээг сар бүр тулган баталгаажуулж, системд үнэн зөв бүртгэж байх
- ❖ Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд оруулж хэвших.
- ❖ Төрийн албан хаагчид олгох орон нутгийн нэмэгдлийг эх үүсвэртээ нийцүүлэн боломжит дүнгээр төсөвт тусган батлуулж, тухайн нэмэгдүүлсэн дүнгээр олгох тухай тогтоолдоо тусгаж, шинээр өр үүсгэхгүй ажиллах, төсвийг алдагдалгүй батлах.
- ❖ Төсөв санхүү, татварын мэргэжилтнүүдийг чадавхжуулах.
- ❖ Төрийн аудитын газрын зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж, зөрчлийг давтахгүй байх.

2.3.2. Төрийн сангийн үйл ажиллагаанд гарч болзошгүй эрсдэлийг зааврын дагуу үнэлж, өдөр тутмын дотоод хяналтыг бүх шатны төрийн сангийн үйл ажиллагаанд тогтмол хэрэгжүүлсэн ч Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн дотоод хяналтын тайланд тусгаагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 4.2-д “Өдөр тутмын хяналтыг төв Төрийн сан, аймаг, нийслэлийн Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системээр дамжуулан түүвэр байдлаар сонгон авч учирч болох эрсдэлээс сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч энэ тухайгаа дотоод хяналтын тайланд тусгаж ажиллахыг хэлнэ”, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын 4.4-д “Өдөр тутмын дотоод хяналтыг “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.9.7-д заасны дагуу төв Төрийн сан болон аймаг нийслэлийн Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн нь харьяа Төрийн сангаас түүвэр байдлаар сонгон авч, хяналтын дэлгэцээс эрсдэлтэй гүйлгээнүүдэд анхаарал хандуулж, эрсдэлээс сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч энэ тухайгаа тухайн жилийн дотоод хяналтын тайланд тусгаж ажиллана” гэж заасны дагуу аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсээс аймгийн болон сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд 2023-2025 онд өдөр тутмын дотоод хяналт хийсэн хэдий ч мэдээ, тайланг Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын 8.1-д заасны дагуу Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн дотоод хяналтын тайланд тусгаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн болон сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутмын дотоод хяналт хийсэн мэдээ, тайланг Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын 8.1-д заасны дагуу



Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлэх дотоод хяналтын тайланд тусгаж ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөлөө.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсээс аймгийн болон сумдын Төрийн сангийн үйл ажиллагаанд 2023-2025 онд хэрэгжүүлсэн өдөр тутмын дотоод хяналтын тоо мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-14 /Төрийн сангийн 2023-2025 оны өдөр тутмын дотоод хяналтаар буцаасан гүйлгээ/

Д/д	Төрийн сангийн нэр	Төрийн сангийн өдөр тутмын дотоод хяналтаар буцаасан гүйлгээний тоо			
		2023 он	2024 он	2025 он	Нийт
1	Баруунтуруун	50	37	70	157
2	Бөхмөрөн	154	212	143	509
3	Давст	127	118	125	370
4	Завхан	93	118	53	264
5	Зүүнговь	168	194	172	534
6	Зүүнхангай	55	40	26	121
7	Малчин	103	138	44	285
8	Наранбулаг	64	75	44	183
9	Өлгий	103	90	46	239
10	Өмнөговь	120	85	65	270
11	Өндөрхангай	314	233	229	776
12	Сагил	52	105	91	248
13	Тариалан	69	129	64	262
14	Түргэн	55	49	62	166
15	Тэс	57	92	70	219
16	Ховд	160	120	71	351
17	Хяргас	184	116	46	346
18	Цагаанхайрхан	32	27	34	93
19	Улаангом	834	692	677	2203
20	Аймгийн Төрийн сан	1615	1640	1832	5087
	Нийт	4409	4310	3964	12683

/Эх сурвалж: Төрийн сангийн өдөр тутмын дотоод хяналтаар буцаасан гүйлгээ /

Хүснэгтээс харахад Төрийн сангийн өдөр тутмын дотоод хяналтаар буцаасан гүйлгээний тоо жил бүр буурсан байна. Тухайлбал: 2024 онд 2023 оноос 2.2 хувиар, 2025 онд 2024 оноос 8 хувиар буурсан байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс дээрх төрийн сангийн өдөр тутмын дотоод хяналтын тоо мэдээллийг нэгтгэн гаргаж сумдын удирдлага, төрийн сангийн ажилтнуудын сургалтын үеэр мэдээлэл өгч ажилласан байна.

2.3.3. Төрийн сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2023-2025 онд Увс аймаг дахь Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой илэрсэн зөрчилд тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж, албан шаардлага хүргүүлж, төлбөрийг акт тогтоож ажилласан. Тухайлбал:



Хүснэгт-15 /Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2023-2025 оны Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнгээс/

/Сая.төгрөг/

№	Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо	Зөрчлийн дүн	Тайлбар
1	Төрийн хэмнэлтийн тухай хууль	26	214.7	Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, овоо тахилга зохион байгуулсан, иргэдэд хүндэтгэл үзүүлсэн, спортын тэмцээн зохион байгуулсан, спортын хувцас, гар утасны нэгж, архи согтууруулах ундаа худалдан авсан зэргээр зориулалт бус зардал гаргасан зөрчил илэрсэн.
2	Эдийн засгийн ангилал зөрчсөн	13	32.4	Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар"-ыг хэрэгжүүлэхгүйгээр гүйлгээ хийсэн.
3	Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт	6	47.7	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас дотоод албан томилолт, хоол, унаа, тээвэр шатахуун, байрны зардал, хэвлэл, хүлээн авалт, бэлэг дурсгалын зүйл, овоо тахилга, тэмдэглэлт өдрийн шагнал урамшуулал зэрэг зардал гаргасан.
4	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	8	385.1	Бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийсэн зөрчил илэрсэн. Тухайлбал: Хөрөнгө оруулалтын ажлыг хүлээн авсан комиссын акт, томилолтын хуудасгүй, тушаал шийдвэргүй, хавсралт баримтгүй гэх мэт
5	Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, илүү цагтай холбоотой	26	197.1	Цалин, урамшууллыг эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр болон давхардуулан олгосон, үндсэн цалинг хөндий нэмэгдүүлсэн, ажлын цагийн балансгүйгээр илүү цагийн хөлс олгосон, ажиллахгүй байгаа хүнд цалин, урамшуулал олгосон, төлбөрийн актыг цалингийн зардлаас төлсөн зэрэг зөрчил гарсан.
6	Няrvын дансаар дамжуулсан	7	92.0	Няrvын дансаар дамжуулан бэлэн мөнгө гаргаж зарцуулсан.

/Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2023-2025 оны статистик мэдээ/



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улаангом сумын Төрийн сангийн 1 мэргэжилтнийг Төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэлд шилжүүлэн ажиллуулж байна.
2. Төрийн сангийн албан хаагчдын гүйцэтгэж буй чиг үүрэг давхардалгүй байна.
3. Санхүү, төрийн сангийн хэлтсийн 6 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт дахь ангилал, зэрэглэлд Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолд нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.
4. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2023-2025 онд нийт 18 суманд төлөвлөгөөт дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 33.3 хувь буюу 6 суманд, мөн төлөвлөгөөт бус дотоод хяналтыг 3 сумын Төрийн санд хэрэгжүүлсэн ч зөрчил давтагдан гарсаар байна.
5. Аймаг, сумдын төрийн сангийн 2023-2025 оны нийт гүйлгээнээс тогтмол зардлын гүйлгээнд түүврийн аргаар хяналт хэрэгжүүлэхэд зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн нийт 95.4 сая төгрөгийн 94 гүйлгээ байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



УВС АЙМАГ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2012, 7045-2315 Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2026. 05. 28 № 8/1085

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн хэмжээнд 19 сум болон аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд "Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл"-д хийсэн нийцлийн аудитын дүгнэлттэй танилцлаа.

Танай байгууллагаас ирүүлсэн дүгнэлтийн төсөлтэй санал нэг байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЭРДЭНЭСҮРЭН



D disk: AZDTG- tamga-5

8526090802



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 8/1085 дугаар албан бичгээр тайлангийн төсөлтэй санал нэг байна гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад:

1. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн зарим албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусгасан ангилал, зэрэглэлд Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолд нийцүүлэн өөрчлөлт оруулах.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад:

1. Дотоод хяналтын төлөвлөлтийг үндэслэлтэй хийж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, дотоод хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах.
2. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн сумдын төрийн санд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж чиглэл өгч ажиллах.

Улаангом сумын Засаг даргад:

1. Төрийн сангийн мэргэжилтний албан тушаалыг төрийн үйлчилгээний ангилал, зэрэглэлд шилжүүлсэн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.



Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар уламжлах санал

- Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/9469 дүгээр бичгээр ирүүлсэн чиглэл нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журам болон Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн хамтарсан 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А122/А-172 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”-тай нийцэхгүй байгааг эрх бүхий байгууллагад уламжлах.
- Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6-д “Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох журам”-ын дараах заалтууд орон нутгийн түвшинд хэрэгжих боломжгүй байна. Энэ нь улсын төсвөөс татаас авдаг аймгийн хувьд улсын төсвийн татаас санхүүжилт сар бүрийн 8-ны өдрөөс хойш санхүүжигддэг болон орон нутгийн орлого төвлөрүүлэлтээс хамаарч журмын цаглаварт хугацааг баримтлах боломжгүй байдал үүсдэг, орон нутгийн хувьд журмын 2.6.10-2.6.14-т заасан зориулалт бүхий зардлын хувьд санхүүжилтийн эрх олголтыг үндэслэн санхүүжүүлдэг зэргээс шалтгаалдаг тул журамд өөрчлөлт оруулахыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах. Үүнд:
 - 2.6.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно.
 - 2.6.2.Аймаг, нийслэлийн Төрийн сан нь энэ журмын 2.4.9, 2.4.13-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг ажлын 2 өдөрт багтаан мөн журмын 24 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан сум, дүүргийн зохих дансанд хуваарилна гэж заажээ.
 - 2.6.3-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Төрийн сан нь энэ журмын 2.6.10-2.6.14-т заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг мөн журмын 2.5.6-д заасантай адилаар санхүүжүүлнэ”.
- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”-т дараах 2 зардлын ангиллын тодорхойлолт хоорондоо нийцэхгүй байх бөгөөд хурал зөвлөгөөн, сургалт, семинарын хоолны зардлыг эдийн засгийн аль ангиллаас гарах нь тодорхойгүй байх тул тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах. Үүнд:

Д/д	Код	Зардлын эдийн засгийн зүйлс	Тодорхойлолт
1	210502	Хоол, хүнс	Хамаарахгүй зүйлс: Хурал зөвлөгөөн сургалт, семинарын хоолны зардал. Энэ нь Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх /210902/ ангилалд бүртгэнэ..... гэж заасан байхад
2	210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	Хамаарахгүй зүйлс: Сургалтад оролцох томилолт, унаа, хоолны зардал . Эдгээр нь Дотоод албан томилолт /210701/, Гадаад албан томилолт /210702/ ангилалд бүртгэгдэнэ гэж тусгасан байна



байгууллагад хянан олгох, Монгол Улсын алсын хараа-2050, Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланг хуулийн хугацаанд цахимаар илгээж байгаа эсэхэд хяналт тавих, тайланг нэгтгэх, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах, удирдлагаар батлуулж ажиллах, Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах/ зэрэг чиг үүрэг тусгасан болон Төрийн сангийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж буй хянах, батлах үүрэгтэй албан хаагчдын хариуцаж буй байгууллагын тоо, санхүүжилтийн хэмжээнээс шалтгаалан ажлын ачаалал харилцан адилгүй байгаа асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах.

5. Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системийн И-Хуулга дэд системээс аль ч төсвийн захирагчийн мэдээг Сангийн яамнаас шууд татах, харах, мэдээ боловсруулах боломжтой байх тул шат дараалсан тайлагналын зохицуулалт нь практик хэрэгжилтийн хувьд ач холбогдолгүй байгаа асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР


АУДИТОР

АУДИТОР

Т.НАМЖИЛ

Т.АМАРМЭНД

Т.БАТСҮХ



Увс аймаг, Улаангом-85160,
Засаг даргын тамгын газрын байр Утас:70453317
И-мэйл: uvs@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn